

On behalf of:



Federal Ministry  
for the Environment, Climate Action,  
Nature Conservation and Nuclear Safety



INTERNATIONAL  
CLIMATE  
INITIATIVE

of the Federal Republic of Germany

# УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ БОЛОН БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН УЯЛДАА ХОЛБОО, ХАМТЫН ҮР НӨЛӨӨГ БЭХЖҮҮЛЭХ БОДЛОГЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Хэрэгжүүлэгч:



Deutsche Gesellschaft  
für Internationale  
Zusammenarbeit (GIZ) GmbH



International Institute for  
Sustainable Development



## Агуулга

1. Оршил.....	3
2. Уур амьсгал болон биологийн олон янз байдлын нөхцөл байдал, институцийн зохион байгуулалт.....	6
3. Уур амьсгалын болон биологийн олон янз байдлын чиглэлд хамаарах үндэсний бодлогын гол баримт бичгүүд.....	10
4. Монгол Улсын ҮТХН, ҮДЗТ болон БОЯБҮХ-ийн хамтын үр нөлөөний үнэлгээний тойм.....	16
5. Уур амьсгал болон биологийн олон янз байдлын хамтын үр нөлөөний үйл ажиллагааг сайжруулахад тулгарч буй сорилтууд.....	24
6. Уур амьсгалын болон биологийн олон янз байдлын хамтын үр нөлөөтэй үйл ажиллагааг бэхжүүлэх боломжууд.....	28



## 1. Оршил

Уур амьсгалын өөрчлөлт болон биологийн олон янз байдлын доройтол нь харилцан уялдаа холбоотой бөгөөд бие биеийнхээ сөрөг нөлөөг улам эрчимжүүлж байдаг. (Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх Засгийн газар хоорондын мэргэжилтнүүдийн хороо [IPCC], 2018; НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн тайлан, 2021). Уур амьсгалын өөрчлөлт нь амьдрах орчныг доройтуулж, төрөл зүйлийн устах үйл явцыг түргэсгэх замаар биологийн олон янз байдлыг алдагдуулах гол хүчин зүйл болж байна. Түүнчлэн экосистемийн доройтол нь түүнд агуулагдах нүүрстөрөгчийн алдагдлыг нэмэгдүүлж, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох болон тэсвэрлэх чадавхыг сулруулснаар экосистемийн сэргэх чадамжийг бууруулдаг. Ийнхүү уур амьсгалын өөрчлөлт болон биологийн олон янз байдлын доройтлын сөрөг харилцан үйлчлэл нь эх дэлхийн өөрийгөө нөхөн сэргээх хязгаарыг даван, эргэх боломжгүй шилжилтийн босгонд хүрэх магадлалыг нэмэгдүүлсээр байна. (Pörtner нар, 2021). Эрдэмтэд эдгээр уялдаа хамаарлыг хүлээн зөвшөөрч байгаа хэдий ч улс орны стратеги, бодлогын баримт бичгүүд нь тэдгээрийг ихэвчлэн салангид авч үздэг тул энэ асуудлыг бүхэлд нь хамарсан уялдаа холбоог хангах бодлого болон хэрэгжилт дутмаг байна.

Иймээс уур амьсгал болон биологийн олон янз байдлын үндэсний стратегиудын засаглал, хэрэгжилтийн нэгдсэн аргагүйн уялдаа холбоог хангах, ялангуяа тухайн улсын Үндэсний тодорхойлсон хувь нэмэр (ҮТХН), Үндэсний дасан зохицлын төлөвлөгөө (ҮДЗТ) болон Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр (БОЯБҮХ) хоорондын уялдааг сайжруулах шаардлага сүүлийн жилүүдэд эрчимтэй өсөж байна. Хэдийгээр хамтын ажиллагааны сайн туршлагууд байгаа хэдий ч энэ нь өөр хоорондоо уялдаа холбоо бүхий нарийн төвөгтэй асуудлуудыг бүрэн шийдвэрлэхэд

хангалтгүй байж болзошгүй юм. Асуудлыг үр дүнтэй шийдвэрлэхийн тулд уур амьсгал, байгаль орчинтой холбоотой бодлогуудыг стратегийн түвшинд уялдуулж, харилцан уялдаатай хэрэгжүүлэх, давхцаж буй асуудлуудыг шийдвэрлэх, уялдаа холбоо бүхий ирээдүйг чиглэсэн, зохицсон шийдлүүдийг тусгах шаардлагатай байна.

Энэхүү бодлогын дүн шинжилгээнд “хамтын үр нөлөө” (synergy) гэдгийг ҮТХН, ҮДЗТ, БОЯБҮХ зэрэг уур амьсгал болон биологийн олон янз байдлын үндэсний амлалт, стратегийн төлөвлөлт, тэдгээрийн хэрэгжилтийг нэгдсэн байдлаар уялдуулан зохицуулах үйл явц хэмээн тодорхойлно. Хамтын үр нөлөө нь “олон талын хамтын үр ашгийг бий болгож, илүү үр нөлөөтэй үр дүнг эрэлхийлж, нэг салбарт гарсан ахиц өөр салбарт сөргөөр нөлөөлөхөөс сэргийлнэ” (Qi нар, 2024). Хамтын үр нөлөөг бий болгоход дээд түвшний шийдвэр гаргагчид болон оролцогч талууд нь дээрх бодлогын бичиг баримтуудын уялдаа холбоог нарийн тодотгож, нөөц бололцоо, зохицуулалтын механизм, үйл явц зэрэг олон бүрэлдэхүүн хэсгийн харилцан үйлчлэлийн талаар ижил түвшинд нэгдсэн ойлголттой байх нь чухал.


Монгол Улсын ҮТХН, ҮДЗТ болон БОЯБҮХ зэрэг баримт бичгүүд хоорондоо хэрхэн уялдаж, ямар сорилт бэрхшээлүүд тулгарч байгаа, уялдуулан төлөвлөж, хэрэгжүүлэх ямар боломжууд байгааг тодорхойлох нь уур амьсгал болон биологийн олон янз байдлын бодлогын уялдаа холбоо, хамтын үр нөлөөг бэхжүүлэх эхний чухал алхам юм. Энэхүү бодлогын баримт бичгүүдийн дүн шинжилгээ нь уур амьсгал болон байгаль хамгааллын бодлогын салбар хоорондын боломжит хамтын үр өгөөжийг нээн тодруулах, цаашдын үр дүнг сайжруулах боломжуудыг хайхаас гадна, Монгол Улсад учирч болох эрсдэл, бэрхшээлүүдийг тодорхойлоход чиглэсэн.

Тус үнэлгээг Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ), Тогтвортой хөгжлийн олон улсын хүрээлэн (IISD), Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн боловсруулсан “Уур амьсгал ба байгаль хамгааллыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх нь: ҮТХН, ҮДЗТ, БОЯБҮХ-ийн хамтын үр нөлөөний шалгах хуудас” (Qi нар, 2024)-т тулгуурлан гүйцэтгэсэн болно. Энэхүү аргачлалаар засаглалын бүтэц, дээд түвшний удирдлага зохион байгуулалтын мандат, стратегийн зорилго ба зорилтууд, бодлогын арга хэмжээ, санхүүжилтийн механизм, хяналт-үнэлгээ, тайлагналын тогтолцоог судлах замаар эдгээр гурван баримт бичгийн давхцал, орхигдол, хийдлийг сайжруулах арга замыг тодорхойлон гаргадаг. Мөн тус бодлогын баримт бичгийн дүн шинжилгээг төрийн захиргааны байгууллагын дунд болон ахлах түвшний албан тушаалтнууд, түүнчлэн эдгээр үйл явцад тус тусын чиглэлээр дэмжлэг үзүүлдэг олон улсын хөгжлийн хамтын ажиллагааны байгууллагуудтай хийсэн ярилцлагаар баяжуулсан болно.

Энэхүү тайлан нь уур амьсгал болон биологийн олон янз байдлыг хамгаалах институцийн тогтолцоо, үндэсний бодлогын гол баримт бичгүүдийн өнөөгийн байдлыг тоймлон танилцуулснаар эхэлнэ. Удаах хэсэгт хамтын үр нөлөөний үнэлгээг хийж, Монгол Улсын ҮТХН, ҮДЗТ болон БОЯБҮХ-үүд нь хэрхэн уялдаж байгааг үнэлж, нийтлэг зорилго, зорилтууд, шалгуур үзүүлэлтүүд, арга хэмжээ, оролцогч талууд, салбарууд, болзошгүй зөрчлүүд болон орхигдол, хийдлийг тодорхойлно. Улмаар цаашдын нягт уялдаа холбоо бүхий хамтын үр нөлөөг бий болгоход учирч болзошгүй сорилт, орхигдол, хийдэл, хүндрэлүүдийг тус тус авч үзнэ. Эцэст нь уур амьсгал болон биологийн олон янз байдлын хүрээнд уялдаа холбоог сайжруулах, зохицуулалтыг бэхжүүлэхэд шаардлагатай хэрэгжихүйц боломжууд болон стратегийн гарцуудыг тодотгон оруулав.

Энэхүү дүн шинжилгээ нь Монгол Улсын ҮТХН,ҮДЗТ, БОЯБҮХ-ийн бодлого боловсруулагчид, төлөвлөгчид, үндэсний зохицуулагчид болон иргэний нийгмийн байгууллагууд уур амьсгал болон биологийн олон янз байдлын бодлого, үйл ажиллагааг илүү уялдуулж, олон талт ашигтай, үр дүн бүхий хэрэгжилтэд хүрэхэд туслах зорилготой юм.

**Хамтын үр нөлөө нь “олон талын хамтын үр ашгийг бий болгож, илүү үр нөлөөтэй үр дүнг эрэлхийлж, нэг салбарт гарсан ахиц өөр салбарт сэргөөр нөлөөлөхөөс сэргийлнэ” (Qi нар, 2024).**



## 2. Уур амьсгал болон биологийн олон янз байдлын нөхцөл байдал, институцийн зохион байгуулалт

Монгол Улс нь Зүүн хойд Азид орших хөгжиж буй орон ба уур амьсгалын өөрчлөлт, биологийн олон янз байдлын доройтлын нөлөөнд тун эмзэг орон. Уул уурхайн бүтээгдэхүүн олборлох, боловсруулах үйлдвэрлэл, бэлчээрийн мал аж ахуй болон хур тунадсаар тэжээгддэг газар тариаланд тулгуурласан хөдөө аж ахуйн салбаруудаас ихээхэн хамаарал бүхий эдийн засагтай, далайд гарцгүй томоохон орнуудын нэг юм. Монгол улс 1990-ээд оноос хойш төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг бүхий нэг намын тогтолцооноос ардчилсан парламентын засаглал, зах зээлийн эдийн засагт шилжихээр тэмүүлсэн байдаг. Хэдий нүүдлийн соёл иргэншлийн уламжлалтай орон ч гэлээ хотжилт, үйлдвэрлэл эрчимтэй нэмэгдэж, нийт хүн амын 70.8 хувь нь суурьшлын бүсэд амьдарч байна (Байгаль орчин, аялал жуулчлалын яам [БОАЖЯ], 2024). Монгол орон нь экосистем, биологийн төрөл зүйлийн хувьд баялаг улс бөгөөд нийт нутаг дэвсгэрийнхээ 32.5 сая га талбайг (нийт талбайн ~20.8%) улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд (ТХГН)-т бүртгээд байна.

Энэ хэсэгт Монгол орны уур амьсгалын өөрчлөлт, биологийн олон янз байдлын нөхцөл байдал, бодлогын төлөвлөлт, хэрэгжилттэй холбогдох институцийн болон засаглалын зохицуулалтыг хураангуйлан дурдав. Тоо баримтыг НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн тухай суурь конвенц (НҮБУАӨСК)-ын хэрэгжилтийн

Үндэсний дөрөвдүгээр тайлан илтгэл (БОАЖЯ, 2024) болон Үндэсний дасан зохицлын төлөвлөгөө (БОУАӨЯ, 2025) -нд үндэслэн боловсруулсан болно.

## 2.1 Уур амьсгал болон биологийн олон янз байдлын нөхцөл байдал

Монгол орон нь тайгын шилмүүст бүсээс эх газрын эрс тэс уур амьсгалын нөхцөл бүхий олон төрлийн экологийн бүс нутгуудад хуваагддаг. Хойд хэсгээрээ тайгын шилмүүст ойн бүсээс эхлээд төв хэсгээр тал хээрийн бүс, цаашлаад өмнөд болон баруун өмнөд хэсэгтээ заримдаг цөл, цөлийн бүс хүртэл үргэлжилдэг. Экологийн бүс нутгуудын олон янз байдал, хүн амын сийрэг тархалт нь Монголын байгалийг өвөрмөц болгодог бол, нөгөө талаар тус бүс нутгуудын шилжилтийн орон зай болон эх газрын эрс тэс уур амьсгал нь биологийн олон янз байдлыг илүү эмзэг байлгадаг байна. Монгол орон нь Төв ба Зүүн Азийн бүсэд ховордсон болон нэн ховордсон олон амьтан, ургамлын хорогдох гэр болдог. Тухайлбал Дэлхийн Байгаль Хамгаалах Сан (WWF)-гийн тодорхойлсон нэн чухал 35 экологийн бүс нутгийн хоёр (Амур-Хэйлонг, Алтай-Саян) нь Монгол улсын нутаг дэвсгэрт хамаарах бөгөөд ЮНЕСКО-ийн Дэлхийн Байгалийн Өвд бүртгэгдсэн хоёр газар, Рамсарын 11 газар, Шувуудад чухал 70 газар багтдаг. Мөн түүнчлэн улсын нийт талбайн ~8.71 хувь нь ойн сан бүхий газар бөгөөд нутгийн хойд хэсэгт шилмүүст ой, баруун өмнө хэсэгт заган ой зонхилон тархсан (Ойн газар, 2026).

Сүүлийн жилүүдэд эрчимжиж буй уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, тогтвортой бус газар ашиглалт, эмзэг экосистемүүдийн хамгаалалт хангалтгүй байгаа зэрэг нь Монгол орны олон төрлийн экосистемд ноцтой эрсдэлийг учруулж байна. Биологийн олон янз байдлын доройтол, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө нь бэлчээрийн мал аж ахуйд түшиглэсэн хөдөөгийн айл өрхүүд төдийгүй хурдацтай өсөж буй хотын хүн амын амьжиргаа, амьдралын чанарт заналхийлж байна. Засгийн газар хоорондын мэргэжилтнүүдийн хорооны Төлөөллийн Концентрацийн Замнал (RCP)-ын дагуу, RCP8.5 (ердийн бизнес нөхцөл, өндөр ялгарлын төсөөлөл) хувилбарт Монгол орны агаарын дундаж температур 2090-ээд онд ойролцоогоор +5.3°C-аар өсөхөөр байгаа нь дэлхийн дундаж +3.7°C-тай харьцуулахад харьцангуй өндөр байна (Дэлхийн Банк, 2021). Харин RCP 6.0, 4.5, 2.6 хувилбаруудад тус бүр +3.4°C, +2.6°C, +1.4°C-ийн өсөлтөөр тооцоологдсон байна (RCP2.6 нь хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах хамгийн хүчтэй хувилбар). Дундаж үзүүлэлтийг давсан энэхүү дулаарал нь хүний эрүүл мэнд, экосистемийн тогтвортой байдалд ноцтой нөлөө үзүүлэхээр байна. Түүнчлэн газар нутгийн зарим хэсгээр жилд унах хур тунадасны хэмжээ нэмэгдсэнээр гол мөрний үер, шар усны үер ихсэх магадлалтай. Зарим бүс нутагт их хэмжээний аадар бороо орж болзошгүй бол харин зарим нутагт нь ган гачиг, шороон шуурга гэх мэт уур амьсгалын нарийн төвөгтэй үзэгдлүүд тохиолдож болох бөгөөд үүнд ган, зуд зэргийг дурдаж болно. Монгол Улс нь цаг агаарын болон бэлчээрийн ган, цөлжилт, шороон шуурга зэрэгт маш өртөмтгий бөгөөд уур амьсгалын өөрчлөлт ихсэх тусам тэдгээрийн давтамж, үргэлжлэх хугацаа нэмэгдэж болзошгүй байна (БОУАӨЯ, 2025).

Монгол орны уур амьсгалын өөрчлөлтийн ирээдүйн төсөөлөл нь биологийн олон янз байдал болон экосистем, ялангуяа хээрийн экосистем болон цэвдэгт бүс нутгийн ландшафтад нөлөөлөхөөр байна. Монгол орны тал хээрийн биомассын алдагдлын хувь хэмжээ нь “дэлхий нийтийн халуун орны ширэнгэн ойн доройтолтой дүйцэхүйц” бөгөөд төрөл зүйл, биомын тархцад өөрчлөлт гарах магадлалтай (БОУАӨЯ, 2025). Дэлхийн дундаж агаарын температур өсөхийн хэрээр цэвдэгт бүс нутгийн тархалт мэдэгдэхүйц буурахаар байна. Тооцооллоор цэвдэгт бүс нутгийн

хамрах талбай 2016–2035 онд 16.46–18.31%, 2046–2065 онд 33–61.23%, энэ зууны төгсгөл гэхэд 74–94.7%-аар тус тус багасахаар байна (БОАЖЯ, 2024). Үүний үр дүнд Монгол орны ургамал, амьтдын амьдрах тохиромжтой орчны тархац мэдэгдэхүйц хэмжээгээр буурахаар байна.

Эцэст нь дурдахад, уур амьсгалын өөрчлөлт нь Монгол улсын эдийн засгийн салбаруудад нөлөөлж, улс орны хөгжил, шинэчлэлийн хүчин чармайлтыг сааруулах төлөвтэй байна. Хамгийн их өртөх салбар нь газар тариалан, мал аж ахуй бөгөөд дэлхийн дулаарлын +1.5°C хувилбарт жилд ойролцоогоор 3 сая ам. доллар, +3°C-ийн үед 12 сая ам. доллар-ын алдагдал хүлээх урьдчилсан тооцоолол гарчээ (Дэлхийн банк, 2021). Гэнэтийн үер, хэт халалт, ус болон агаарын бохирдол зэрэг нь хотын хүн амд цаашлаад хөдөлмөрийн зах зээлд сөргөөр нөлөөлж, энэ нь хөдөлмөрийн бүтээмжийг бууруулан, улс орны эрчим хүчний хэрэглээнд сөргөөр нөлөөлөх болно. Эдгээр нь ядуурал, тэгш бус байдалтай хавсарсан тохиолдолд Монгол Улс уур амьсгалын өөрчлөлт болон түүнтэй холбоотой гамшигт үзэгдэлд өртөх эмзэг байдал нэмэгдэх юм.

## 2.2 Институцийн зохион байгуулалт

Монгол Улсын Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам (БОУАӨЯ, хуучнаар БОАЖЯ) нь уур амьсгалын өөрчлөлт, биологийн олон янз байдалтай холбоотой бодлого, хөтөлбөрүүдийг боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг удирдан чиглүүлдэг. Тус яам нь үндэсний хэмжээнд болон орон нутгийн түвшинд, мөн олон улсын болон дотоодын оролцогч талуудын хоорондын зохицуулалтын үүргийг гүйцэтгэдэг. БОУАӨЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газар нь уур амьсгалын өөрчлөлтийн бодлого, хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилтийг, харин Байгалийн нөөцийн бодлого, зохистой ашиглалтын газар нь биологийн олон янз байдлын бодлого, хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилтийг тус тус хариуцдаг. Үүний зэрэгцээ, Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв нь хүлэмжийн хийн тооллого хийх, НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн тухай суурь конвенцод (НҮБУАӨСК) хүргүүлэх үндэсний тайлан мэдээг бэлтгэх, судалгаа, технологи дамжуулалт болон бусад уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой үйл ажиллагаанд оролцох үүрэгтэй.

Уур амьсгалын өөрчлөлтийн засаглалыг бэхжүүлэх зорилгоор Монгол Улс 2023 онд Уур Амьсгалын Үндэсний Хороо (УАҮХ)-г шинэчлэн байгуулж, уг хороог Шадар сайд ахлан, БОАЖЯ-ны (хуучин нэрээр) сайд орлогч даргаар ажиллаж, салбар болон яамд хоорондын шийдвэр гаргах дээд түвшний институцын үүргийг гүйцэтгэх болсон. Тус хороо нь НҮБУАӨСК, Парисын хэлэлцээрийн хүрээнд Монгол Улсын хүлээсэн үүрэг амлалтыг биелүүлэх зорилгоор үндэсний хэмжээнд хэрэгжүүлж буй арга хэмжээг зохицуулах, салбар хоорондын уялдаа холбоог хангах үүрэгтэй. Мөн газрын доройтлыг бууруулах, уур амьсгалын тэсвэртэй байдлыг дэмжих зорилго бүхий “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлдэг. УАҮХ-ны бүрэлдэхүүнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар; УИХ-ын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо; УИХ-ын Цөлжилттэй тэмцэх лобби бүлэг; Эдийн засаг, хөгжлийн яам; Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам; Эрчим хүчний яам; Гадаад харилцааны яам; Боловсрол, шинжлэх ухааны яам (хуучин нэрээр); Соёлын яам (хуучин нэрээр); Эрүүл мэндийн яам; Нийслэлийн Засаг даргын Тамгын газар; Онцгой байдлын ерөнхий газар; Усны газар; Ойн газар; Уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн Онцгой Элч; Шинжлэх ухааны академи; “Үндэсний цэцэрлэгт хүрээлэн” ТӨҮГ зэрэг байгууллагын төлөөлөл багтдаг. УАҮХ-ны дэргэд Мэргэжлийн зөвлөл ажиллаж, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой асуудлаар шийдвэр гаргах

үйл явцыг шинжлэх ухаанд тулгуурласан мэдээллээр хангадаг. УАҮХ нь мөн үндсэн болон салбарын яамд, бусад оролцогч талуудын үр дүнтэй хамтын ажиллагааг хангах, ҮТХН болон ҮДЗТ-г батлах ажлыг удирдах, зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй.

Монгол Улсын уур амьсгалын өөрчлөлт болон биологийн олон янз байдлын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл явцыг олон улсын хөгжлийн түншүүд дэмжин ажилладаг. Гурав дахь удаагийн шинэчлэн боловсруулсан ҮТХН (ҮТХН 3.0)-ийн зорилтуудыг ҮТХН-ийн Түншлэл (NDC Partnership), Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ), НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ), Азийн хөгжлийн банк (АХБ), НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Хүүхдийн сангийн суурин төлөөлөгчийн газрууд дэмжин ажилласан байна. Монгол улсын ҮДЗТ боловсруулалтын үйл явцыг НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр, Уур амьсгалын ногоон сангийн бэлэн байдлын хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн. Харин БОЯБҮХ-ийг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр боловсруулж байна.



### **3. Уур амьсгалын болон биологийн олон янз байдлын чиглэлд хамаарах үндэсний бодлогын гол баримт бичгүүд**

Монгол Улс нь байгаль орчны чиглэлээрх олон улсын томоохон конвенци, гэрээ хэлэлцээрүүдийн ихэнхэд нэгдэн орсон бөгөөд тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа мөн хамаарна. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, мөн биологийн олон янз байдлыг хамгаалах талаар олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд үндэсний хэмжээний хэд хэдэн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байна. Энэ хэсэгт Монгол Улсын уур амьсгал болон биологийн олон янз байдлын талаарх үндэсний голлох стратеги, тогтолцоог тоймлон оруулав.

#### **3.1 «Алсын хараа-2050» Үндэсний хөгжлийн бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөө**

Монгол Улсын Засгийн газар 2020 онд үндэсний хөгжлийн урт хугацааны стратегийн баримт бичиг болох "Алсын хараа-2050"-ыг баталж, нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлт, иргэдийн амьдралын чанараар Азийн тэргүүлэгч орон болох цогц тогтолцооны бодлогыг тодорхойлсон. Энэхүү стратегийн баримт бичигт Монгол Улсын уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой бодлогын тэргүүлэх чиглэл, хэтийн зорилтуудыг тодотгож өгсөн байдаг. "Алсын хараа-2050" нь дэлхийн уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх үйл ажиллагаанд өөрийн амлалтаа онцолж, хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох зорилтот арга хэмжээг багтаасан. Тус баримт бичиг нь уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх болон

түүнд дасан зохицох зорилтот арга хэмжээнүүдийг тусгаж, уур амьсгалын бодлогын эрх зүйн болон институцийн тогтолцоог сайжруулах, нүүрстөрөгчийн ялгаруулалт багатай, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй эдийн засагт шилжих эрх зүйн орчны заалтуудыг багтаасан (Монгол Улсын Засгийн газар, 2020).

### 3.2 Шинэ сэргэлтийн бодлого

Шинэ сэргэлтийн бодлого нь дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх замаар Монгол Улсын цар тахлын дараах сэргэлтийг дэмжих зорилготой. Мөн "Алсын хараа-2050"-ын хүрээнд нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлт, иргэдийн амьдралын чанарыг сайжруулах зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн. Шинэ сэргэлтийн зургаан багц чиглэлд: боомтын хөгжил, эрчим хүч, үйлдвэржилт, хот-хөдөөгийн сэргэлт, ногоон өсөлт, төрийн бүтээмж багтдаг. Ногоон өсөлтийн багцын цөм нь байгаль орчинд ээлтэй хөгжил бөгөөд ширгэсэн нуур, цөөрөм, гол горхийг сэргээх, говийн бүс рүү ус татан далан болон усан сан байгуулах зэргийг багтаасан. Мөн 2030 он гэхэд Монгол орны ойгоор бүрхэгдсэн талбайг 9 хувьд хүргэх зорилго бүхий "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн багтана (Монгол Улсын Засгийн газар, 2021).

### 3.3 Үндэсний тодорхойлсон хувь нэмэр (ҮТХН, NDC)

Монгол Улс 2020 онд ҮТХН-ийн зорилтоо хоёр дахь удаагаа шинэчлэн боловсруулж, НҮБУАӨСК-ын Нарийн бичиг нарын газарт хүргүүлсэн бөгөөд 2030 он гэхэд хүлэмжийн хийн ялгарлыг 22.7 хувиар бууруулах зорилтыг дэвшүүлсэн. Тус зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд эрчим хүч, хөдөө аж ахуй, зам тээвэр, аж үйлдвэр, барилга, хог хаягдлын менежмент зэрэг гол салбарын 24 үндсэн зорилтыг хамарсан 72 арга хэмжээг нарийвчлан тусгаж, уур амьсгалын эдгээр зорилтуудыг хэрэгжүүлэх стратегийн хүрээг тодорхойлсон. Хэдийгээр өргөн цар хүрээг хамарсан ч энэ төлөвлөгөөнд жендэрийн мэдрэмжтэй зорилт, шалгуур үзүүлэлт, төсвийн зохицуулалт тусгагдаагүй. Мөн уур амьсгалын өөрчлөлтийн эмэгтэйчүүд болон бусад эмзэг бүлгийн хүн амд үзүүлэх тодорхой нөлөөллийг бууруулахад чиглэсэн зорилт, шалгуур үзүүлэлт, санхүүгийн механизм төдийлөн хангалттай дурдагдаагүй байна (НҮБХХ, 2025).

Монгол Улс уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг 2035 он хүртэл авч хэрэгжүүлэх шинэчилсэн зорилт болох ҮТХН 3.0 баримт бичгийг Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 91 дүгээр тогтоолоор баталсан. Шинэчилсэн ҮТХН-ийн зорилтод Монгол Улс өөрийн нөөц боломжоор буюу нөхцөлт бус арга хэмжээг хэрэгжүүлснээр 2035 он гэхэд нийт 24.7 сая тонн буюу 30.3 хувиар хүлэмжийн хийг бууруулах боломжтой гэж тооцсон ба биологийн олон янз байдал, усны нөөц, ой, гамшгийн менежмент, мал аж ахуй, бэлчээр, газар тариалан, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, боловсрол, соёл зэрэг дасан зохицох 10 тэргүүлэх салбарын зорилтыг тус тус тодорхойлсон. Шинэчлэн батлагдсан ҮТХН нь Парисын хэлэлцээрийн хүрээн дэх уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг дэлхийн улс орнуудын үйл ажиллагааны ахиц дэвшлийн үнэлгээ буюу улс орнуудын уур амьсгалын бодлогыг сайжруулахад чиглэсэн иж бүрэн үнэлгээ болох дэлхийн нэгдсэн үнэлгээ (Global stocktake)-ний үр дүн болон сургамжийг тусгасан болно. Мөн Монгол Улсын ҮТХН 2.0-ийн үнэлгээний дүгнэлт, үр дүн дээр үндэслэн шинэчлэн баталсан ҮТХН 3.0-т уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох зорилтууд, арга хэмжээг улам гүнзгийрүүлэн сайжруулсан байна.

### 3.4 Үндэсний дасан зохицлын төлөвлөгөө (ҮДЗТ, NAP)

Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох хүчин чармайлтыг удирдан чиглүүлэх зорилт бүхий 2030 он хүртэлх Монгол Улсын ҮДЗТ-г Уур амьсгалын Үндэсний хороо 2024 онд баталсан байна. ҮДЗТ-ний үндсэн зорилго нь салбар хоорондын уялдаа холбоо бүхий зохицуулалтаар уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байдлыг бэхжүүлэх, дасан зохицох чадавхыг нэмэгдүүлэх, эмзэг байдлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшгийн эрсдэлд бэлэн байдлыг сайжруулахад оршино (БОУАӨЯ, 2025). Тус төлөвлөгөөнд дасан зохицох тэргүүлэх чиглэлүүд болох хөдөө аж ахуй, ус, эрүүл мэнд, биологийн олон янз байдал, дэд бүтэц, ойн аж ахуй, хот байгуулалт, гамшгийн эрсдэлийн менежмент зэрэг гол салбаруудын зорилтот арга хэмжээг тодорхойлсон. Түүнчлэн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох бодлого, хууль эрх зүй, бүтэц, зохион байгуулалтын үндсийг бэхжүүлэхийн сацуу гол оролцогч талуудын мэдлэгийн бааз, чадавхыг нэмэгдүүлэхэд чиглэсэн салбар дундын зорилтуудыг дэвшүүлсэн байна.

### 3.5 Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр (БОЯБҮХ, NBSAP)

Монгол Улсын Засгийн газар НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр Биологийн олон янз байдлын конвенцын Куньмин-Монреалын Дэлхийн биологийн олон янз байдлын хүрээ баримт бичигтэй уялдуулан шинэчилсэн төслийг боловсруулж байна. Энэхүү үйл явц нь одоогоор хүчин төгөлдөр хэрэгжиж буй БОЯБҮХ (2015-2025)-ийн хэрэгжилтийн байдалд үнэлгээ хийж, уур амьсгалын болон хөгжлийн бодлогууд Куньмин-Монреалын Дэлхийн биологийн олон янз байдлын хүрээ баримт бичигтэй хэрхэн уялдаж байгаа талаарх иж бүрэн үнэлгээгээр эхэлсэн. Оролцогч талуудыг өргөн хамруулахын тулд үндэсний хэмжээнд шат дараалсан зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулж, биологийн олон янз байдлын бодлогын төлөвлөлтөд доороос дээш чиглэсэн арга зүйг ашигласан. БОЯБҮХ-ийн төсөл нь 2030 он гэхэд биологийн олон янз байдлын хомсдолын үндсэн шалтгааныг арилгах, тэргүүлэх ач холбогдол бүхий доройтсон газар нутаг болоод усны нөөцийн 30-аас доошгүй хувийг нөхөн сэргээх зорилт тавьсан. Энэ нь таван стратегийн шилжилтийн дагуу хариу арга хэмжээнүүдийг төлөвлөсөн байна. Үүнд: үр дүнд суурилсан хэрэгжилт, байгалийн нөөцийг бодитой үнэлэх ба үнэ тогтоох, орон зайн уялдааг хангах, шударга шилжилтийг дэмжих, мэдлэг ба оролцоог нэмэгдүүлэх зэрэг багтана. Тус төлөвлөгөөний хамрах хүрээ нь дараах есөн хэрэгжилтийн чиглэлийг багтаасан. Үүнд: экологийн сүлжээ ба нөхөн сэргээх үйл ажиллагаа; гол мөрөн ба усны аюулгүй байдал; төрөл зүйлийн сэргээн хамгаалалт, биоаюулгүй байдал ба харь зүйлсийн менежмент; нүүрстөрөгч бага ялгаруулах дулаан хангамж бүхий байгальд ээлтэй хотууд; тогтвортой үйлдвэрлэлийн ландшафт; хориглолтын бүсийн зохицуулалт бүхий биологийн олон янз байдалд сөрөг нөлөөгүй дэд бүтэц; генетик нөөц, уламжлалт мэдлэг, хүртээмж ба үр ашгийн хуваарилалт; мэдлэг ба инноваци; оролцоог хангасан засаглал болон тэгш үр өгөөж багтана.

### 3.6 Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл

Монгол Улс нь хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, дасан зохицох чиглэлээр баримтлах зарчим, урт хугацааны зорилго, зорилт, түүнчлэн уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг стратегийн хэрэгжилтийг хангах чухал хэрэгсэл болох Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төслийг боловсруулж байна. Энэхүү хуулийн төсөл нь уур амьсгалын бодлогын засаглалыг бэхжүүлэх, салбар хоорондын уялдаа

холбоог сайжруулах, мэдээллийн найдвартай тогтолцоог бий болгох, шинжлэх ухаанд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжихэд чиглэсэн байна. Уг хууль нь Монгол Улсыг нүүрстөрөгч бага ялгаруулдаг, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй ирээдүй рүү шилжихэд дэмжлэг үзүүлж, олон улсын уур амьсгалын санхүүжилтийг татахад эерэг нөлөө үзүүлэх болно.

Тус хуулийг батлан хэрэгжүүлснээр Монгол Улсын Засгийн газар нүүрстөрөгчийн ялгарал багатай эдийн засаг руу шилжих зайлшгүй шаардлагыг бүрэн ухамсарлан хүлээн зөвшөөрч, энэ чиглэлд тууштай, идэвхтэй ажиллах хүчин чармайлтаа батлан харуулж буй явдал юм.

*Хүснэгт 1. Монгол улсын уур амьсгал болон биологийн олон янз байдалтай холбоотой үндсэн стратеги, бодлогын хүрээ болон хууль тогтоомжийн тойм*

*Стратеги, бодлогын хүрээ, хууль тогтоомж*

Алсын хараа 2050 Үйл ажиллагааны төлөвлөгөө	Шинэ сэргэлтийн бодлого	ҮТХН 3.0 (NDC 3.0)	ҮДЗТ (NAP)	БОЯБҮХ (NBSAP)	Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл
<b>Төлөв</b>					
Боловсруулсан /хэрэгжиж байгаа	Боловсруулсан /хэрэгжиж байгаа	Боловсруулсан /хэрэгжиж байгаа	Боловсруулсан /хэрэгжиж байгаа	Боловсруулж байгаа	Боловсруулж байгаа
<b>Хугацаа</b>					
2020–2050	2021–2031	2025–2035	2024–2030	Одоогоор шинэчлэгдэж байгаа	Хамаарахгүй
<b>Хариуцаж буй байгууллага</b>					
Эдийн засаг, хөгжлийн яам (ЭЗХЯ)	Монгол Улсын Засгийн газар	БОУАӨЯ (Бодлого төлөвлөлтийн газар)	БОУАӨЯ (Бодлого төлөвлөлтийн газар)	БОУАӨЯ (Байгалийн нөөцийн бодлого, зохистой ашиглалтын газар)	БОУАӨЯ, ЭЗХЯ
<b>Алсын хараа</b>					
2050 он гэхэд Монгол Улс нь нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлт, иргэдийн амьдралын чанараар	Шинэ сэргэлтийн бодлого нь Монгол Улсын эдийн засгийн хараат бус байдлыг бэхжүүлэх, цар тахал (COVID-19)-ын эдийн	Монгол Улс нь хүлэмжийн хийн ялгаруулалтыг газар ашиглалт, газар ашиглалтын өөрчлөлт, ойн салбарыг	Монгол Улсын байгаль орчин, нийгэм, эдийн засгийн салбарын уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхыг нэмэгдүүлэх, байгаль,	Монгол Улс 2030 он гэхэд голлох экосистемүүд болон тэдгээрийн тэнцвэртэй байдлыг хангах экологийн холбоос	Энэ хуулийн зорилго нь уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, түүнд дасан зохицох болон даван туулах, хүлэмжийн хийн тэнцлийг хангахад

### Алсын хараа

Азийн тэргүүлэгч орон болно.	засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хөгжлийн саад бэрхшээлийг нэн даруй шийдвэрлэхэд чиглэнэ.	оруулалгүйгээр бизнесийн ердийн хувилбартай харьцуулахад 2030 он гэхэд 23 хувь, 2035 он гэхэд 30.3 хувиар бууруулах зорилтыг хэрэгжүүлэх-ээр зорьж байна.	цаг уурын нөлөөллөөс шалтгаалсан гамшигт тэсвэртэй байдлыг бэхжүүлэх, эмзэг байдал, түүнтэй холбоотой эрсдлийг бууруулах зорилго тавьсан.	нутгуудыг хамгаалж, нэн тэргүүний ач холбогдолтой доройтсон газар нутаг болон усны 30-аас доошгүй хувийг нөхөн сэргээж, экологийн хамгаалагдсан урсац бүхий гол мөрнүүдийг хадгалан хамгаалж, хүний үйл ажиллагаан-аас үүдэлтэй устаж үгүй болох эрсдэлийг бууруулж, хот суурин, үйлдвэрлэл-эдийн засгийн ландшафт болон дэд бүтцийн хөгжилд байгаль, хүн төвтэй хандлагыг төлөвшүүлэн байгалийн хүн төрөлхтөнд үзүүлэх хувь нэмрийг өргөжүүлнэ.	чиглэсэн байгаль орчин, эдийн засаг, нийгмийн тогтвортой байдлыг хангах, карбон зах зээлийг бүрдүүлэх, уур амьсгалын санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх, түүнчлэн уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой бүртгэл, мэдээллийн сан, тайлагналын нэгдсэн тогтолцоог бий болгоход оршино.
------------------------------	--	---	---	--	--

### Тэргүүлэх салбарууд

<ul style="list-style-type: none"> <li>• Уул уурхай</li> <li>• Хөдөө аж ахуй</li> <li>• Эрчим хүч</li> <li>• Мэдээлэл технологи, бүтээлч үйлдвэрлэл</li> <li>• Аялал жуулчлал</li> <li>• Тээвэр ложистик</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Боомтууд</li> <li>• Эрчим хүч</li> <li>• Аж үйлдвэр</li> <li>• Хот, хөдөө</li> <li>• Ногоон хөгжил</li> <li>• Төрийн бүтээмж</li> </ul>	<p><u>Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах</u></p> <ul style="list-style-type: none"> <li>• Эрчим хүч</li> <li>• Барилга байгууламж</li> <li>• Аж үйлдвэрийн процесс ба бүтээгдэхүүний хэрэглээ (АҮПБХ)</li> <li>• Хог хаягдал</li> <li>• Тээвэр</li> <li>• Хөдөө аж ахуй</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Эко систем, биологийн олон янз байдал, газрын доройтол</li> <li>• Усны нөөц ба хангамж</li> <li>• Ойн аж ахуй</li> <li>• Цаг уур, байгалийн гамшиг</li> <li>• Мал аж ахуй, бэлчээр</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Экологийн сүлжээ, нөхөн сэргээлт</li> <li>• Гол мөрөн, усны аюулгүй байдал</li> <li>• Зүйлүүд, био аюулгүй байдал, инвазив харь зүйлс</li> <li>• Нүүрстөрөгч бага ялгаруулах дулаан хангамж, уур амьсгал, байгальд ээлтэй хотууд</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Эдийн засгийн бүх салбарууд</li> </ul>
---	--	---	--	--	---

**Тэргүүлэх салбарууд**

	<p><u>Дасан зохицох</u></p> <ul style="list-style-type: none"> <li>• Биологийн олон янз байдал</li> <li>• Усны нөөц</li> <li>• Ойн нөөц</li> <li>• Гамшгийн эрсдэлийг бууруулах</li> <li>• Мал, бэлчээрийн менежмент</li> <li>• Газар тариалан-гийн үйлдвэрлэл</li> <li>• Нийгмийн эрүүл мэнд</li> <li>• Амьжиргаа, нийгмийн хамгаалал</li> <li>• Боловсрол</li> <li>• Соёл</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Тариалан-гийн аж ахуй</li> <li>• Нийгмийн эрүүл мэнд</li> <li>• Нийгмийн хамгаалал</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Тогтвортой үйлдвэрлэл-эдийн засгийн ландшафтууд</li> <li>• Биологийн олон янз байдлын аюулгүй дэд бүтэц, хориглолтын бүсийн зохицуулалт</li> <li>• Генетик нөөц, уламжлалт мэдлэг, хүртээмж ба үр ашгийн хуваарилалт</li> <li>• Мэдлэг, инноваци, цахимжсан Хэмжилт, Тайлагналт, Баталгаажуулалт (MRV) болон оролцоо</li> </ul>
--	--	--	--

Эх сурвалж: Монгол Улсын Засгийн газар, 2020; Монгол Улсын Засгийн газар, 2021; БОУАӨЯ, 2025 он



## 4. Монгол Улсын ҮТХН, ҮДЗТ болон БОЯБҮХ-ийн хамтын үр нөлөөний үнэлгээний тойм

Доорх тойм хүснэгтэд Монгол Улсын уур амьсгал, биологийн олон янз байдалтай холбоотой гурван баримт бичиг, үндэсний хөгжлийн төлөвлөгөө, Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төслийн уялдаа холбоо, зөрүүтэй байдлуудыг тодорхойлсон болно. Үнэлгээний дүгнэлт нь холбогдох баримт бичгүүдийн агуулгын нарийвчилсан шинжилгээ, асуудал хариуцсан мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагын үндсэн дээр хийгдсэн болно. Хүснэгт 2-т одоогийн засаглалын бүтцийг харьцуулан үнэлж, дараах стратегийн элементүүдийн хүрээнд судалсан болно:

*Стратегийн элементүүдийн хүрээ*



## Хүснэгт 2. Монгол Улсын УТХН, ҮДЗТ, ба БОЯБҮХ-ийн хамтын үр нөлөөллийн үнэлгээний тойм

УТХН 3.0-ын үйл явц	ҮДЗТ-ний үйл явц	БОЯБҮХ-ийн үйл явц	Хамтын үр нөлөөний үнэлгээ
<p>✓ Хүлэмжийн хийн ялгаруулалтын тооллогын дүнг УТХН 3.0-т оруулсан.</p> <p>* Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, дасан зохицох, биологийн олон янз байдлыг чиглэлийн мэргэжилтнүүд УТХН 3.0-ыг</p>	<p>✓ ҮДЗТ баримт бичиг нь уур амьсгалын эрсдэл, эмзэг байдлын үнэлгээг агуулсан.</p> <p>* ҮДЗТ боловруулалтын үйл явцад биологийн олон янз байдлын чиглэлийн мэргэжилтнүүдийг татан оролцуулсан.</p>	<p>✓ БОЯБҮХ нь Биологийн олон янз байдал ба экосистемийн үйлчилгээний талаарх Засгийн газар хоорондын шинжлэх ухаан–бодлогын платформ (IPBES)-ын аргачлалд суурилсан биологийн олон янз байдлын доройтлын үнэлгээг (уур амьсгалын</p>	<p>✗ БОУАӨЯ, УАУХ эсвэл Засгийн газрын түвшинд УТХН, ҮДЗТ, БОЯБҮХ-ийг албан ёсоор уялдуулах, эсвэл харилцан иш татаж тусгах талаарх зохицуулалт одоогоор байхгүй байна. Дээд түвшний хэмжээнд тодорхой бүрэн эрх, чиглэл байхгүй байгаа тул Монгол Улсын бодлого төлөвлөлтийн орчин салангид хэвээр байгаа бөгөөд олон улсын хөгжлийн түнш байгууллагууд бие даасан зөвлөхүүд болон төсөл хөтөлбөрүүдэд суурилсан арга барилаар дээрх баримт бичгүүдийн хүрээнд тус тусын хамаарах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>* Уур амьсгалын Үндэсний хороо нь уур амьсгалын өөрчлөлтийг зохицуулах хэвтээ механизм ба харин БОУАӨЯ-ны Байгалийн нөөцийн бодлого, зохистой ашиглалтын газар нь биологийн олон янз байдлын асуудлыг хариуцан зохицуулагч (CBD Focal Point) бөгөөд БОЯБ, Картагены протокол, Нагоягийн протоколыг хэрэгжүүлэх дотоодын зохицуулалтыг хариуцдаг. Энэ хоёр зохицуулалтын механизм хэрхэн харилцан үйлчлэх нь одоогоор тодорхойгүй байна.</p> <p>✓ УТХН 3.0-ын зорилтуудыг шинэчлэн боловсруулах үйл явцын хүрээнд жендэрийн зорилтот зөрүүтэй байдлын үнэлгээг хийсэн. “Уур амьсгалын бодлогод жендэрийн мэдрэмжтэй хандлагууд байхгүй байгаа нь хүртээмжтэй байдал, тэгш оролцоог хязгаарладаг” (НҮБХХ, 2025) болохыг тогтоосон байна. УТХН 3.0 нь Монгол Улсын уур амьсгалын үйл ажиллагаанд жендэрийн тэгш байдлыг уялдуулах, бэхжүүлэх шинэ боломжийг олгож байна. ҮДЗТ-нд дасан зохицох тэргүүлэх арга хэмжээнүүдийн хүрээнд жендэрийн шинжилгээ хийхээр төлөвлөсөн бол биологийн олон янз байдлын талаарх шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдлыг хангах асуудлыг БОЯБҮХ-ийн төслийн 19 дүгээр зорилтод тусгасан байна.</p>
<p>✓</p>	<p>✓ ҮДЗТ баримт бичиг нь уур амьсгалын эрсдэл, эмзэг байдлын үнэлгээг агуулсан.</p> <p>* ҮДЗТ боловруулалтын үйл явцад биологийн олон янз байдлын чиглэлийн мэргэжилтнүүдийг татан оролцуулсан.</p>	<p>✓ БОЯБҮХ нь Биологийн олон янз байдал ба экосистемийн үйлчилгээний талаарх Засгийн газар хоорондын шинжлэх ухаан–бодлогын платформ (IPBES)-ын аргачлалд суурилсан биологийн олон янз байдлын доройтлын үнэлгээг (уур амьсгалын</p>	<p>* Тус баримт бичгүүд нь бие биенийхээ үнэлгээг хэсэгчлэн иш татаж оруулсан байна. Одоогоор боловсруулагдаж буй БОЯБҮХ-ийн төсөлд ҮДЗТ-өөс тодорхой хэсгүүдийг иш татсан бөгөөд биологийн олон янз байдалтай холбоотой уур амьсгалын эмзэг байдлыг онцолсон байна. Мөн УТХН-т дурдагдсан байгальд суурилсан шийдлүүд нь хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах боломжтой тухай онцолж өгсөн. ҮДЗТ-нд УТХН-ийг дурдаж, Монгол Улсын хүлэмжийн хийн ялгарал,</p>

Дээд түвшний  
удирдлага зохион  
байгуулалтын мандат

Үнэлгээ

ҮТХН 3.0-ын үйл явц	ҮДЗТ-ний үйл явц	БОЯБУХ-ийн үйл явц	Хамтын үр нөлөөний үнэлгээ
<p>боловсруулах холбогдох ажлын хэсгүүдэд орж ажилласан.</p> <p>✓ ҮТХН 3.0-т хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах тэргүүлэх салбаруудыг багтаасан бөгөөд уур амьсгалын эрсдэлд өндөр өрөмтгий тэргүүлэх салбаруудыг тодорхойлсон.</p> <p>✓ ҮТХН 3.0-т зориулсан Жендерийн зорилтот зөрүүтэй байдлын үнэлгээг хийсэн.</p>	<p>боловч БОЯБУХ-ийн үйл явцтай уялдаагүй.</p> <p>✓ ҮДЗТ нь тэргүүлэх ач холбогдол бүхий болон салбар дундын 10 салбарыг багтаасан.</p> <p>✓ ҮДЗТ-ний дасан зохицох тэргүүлэх үйл ажиллагааны нэг хэсэг болгон жендерийн үнэлгээ хийхээр төлөвлөсөн.</p>	<p>нөлөөллийг оролцуулан) багтаасан.</p> <p>* БОЯБУХ-ийн төлөвлөлтийн үйл явцад ҮТХН 3.0 болон ҮДЗТ-г боловсруулсан хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, дасан зохицох чиглэлийн мэргэжилтнүүдийг оролцуулаагүй ч уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлийн мэргэжилтнүүд оролцсон.</p> <p>✗ БОЯБУХ нь тэргүүлэх салбаруудыг тусгаагүй боловч хэрэгжүүлэх чиглэлүүдийг тодорхойлсон.</p> <p>✓ БОЯБУХ нь биологийн олон янз байдалтай холбоотой шийдвэр гаргахад жендерийн тэгш байдлыг хангах асуудлыг 19 дүгээр зорилт болгон тусгасан.</p>	<p>тооллогын үр дүнг тоймлон харуулсан. ҮТХН 3.0-т БОЯБУХ эсвэл ҮДЗТ-ний талаар тодорхой дурдаагүй ч уур амьсгалын болзошгүй эрсдэл, нөлөөллийг багтаасан.</p> <p>✗ Тухайн 3 баримт бичиг тус бүр нь бусдынхаа холбогдох оролцогч талуудыг хамруулаагүй байна. Холбогдох үйл явцын цаг хугацааны зөрүү, бодлогын салангид байдал, олон улсын хөгжлийн түншүүд болон зөвлөхүүдийн олон талт оролцоо нь оролцогч талуудын хамтын оролцоог хангахад хүндрэл учруулж байна. Хөгжлийн түншүүд болон зөвлөхүүдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах дээд түвшний удирдлага, зохион байгуулалтын мандаг дутмаг байгаа нь хамтын хүчин чармайлтыг үр дүнтэй гаргахад саад учруулж байна.</p> <p>✓ ҮТХН 3.0 болон ҮДЗТ-ний нэн эмзэг гэж тодорхойлсон тэргүүлэх салбарууд нь өөр хоорондоо уялдсан байна. Гэхдээ ҮТХН 3.0-т эрчим хүч, барилга, тээвэр, хог хаягдал, аж үйлдвэр зэрэг ҮДЗТ-нд багтаагүй бусад салбаруудыг оруулсан. БОЯБУХ нь тэргүүлэх салбаруудыг тодорхой авч үзээгүй боловч зарим арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэл нь хөдөө аж ахуй, ойн аж ахуй зэрэг тэргүүлэх салбаруудтай уялдаж байна.</p>

ҮТХН 3.0-ын үйл явц	ҮДЗТ-ний үйл явц	БОЯБУХ-ийн үйл явц	Хамтын үр нөлөөний үнэлгээ
<p>✗ ҮТХН 3.0-д уур амьсгал, байгаль орчинтой холбоотой нийтлэг өгүүлэмж, мэдэгдлийг оруулаагүй.</p> <p>* ҮТХН 3.0-д дасан зохицох бүрэлдэхүүн хэсэг багтсан боловч уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох зорилтуудыг хэрэгжүүлэх үндсэн механизм болох ҮДЗТ-г тусгайлан дурдаагүй.</p>	<p>✗ ҮДЗТ-нд уур амьсгал, байгаль орчинтой холбоотой нийтлэг өгүүлэмж, мэдэгдлийг оруулаагүй.</p> <p>✓ ҮДЗТ нь БОЯБУХ-ийг дурдаж, түүнийг батлах, хэрэгжүүлэхийг нэн тэргүүний арга хэмжээ гэж тодорхойлсон. ҮДЗТ-д зорилго, хамрах хүрээ, үйл ажиллагааг ҮТХН-тэй уялдуулах тухай дурдсан байна. Мөн ҮДЗТ нь "Алсын хараа</p>	<p>✓ БОЯБУХ-ийн төсөлд уур амьсгалын өөрчлөлт, түүний биологийн төрөл зүйлд үзүүлэх нөлөөллийн талаар дэлгэрэнгүй дурдсан.</p> <p>✓ БОЯБУХ-ийн төсөлд ҮДЗТ болон ҮТХН-ийн хэсгүүдээс иш татсан.</p> <p>* БОЯБУХ нь нүүрстөрөгчийн шингээгч болох экосистемийг хамгаалах, сайжруулах замаар уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох болоод хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулахын ач</p>	<p>✗ Гурван баримт бичиг нь жендерийн талаар нийтлэг хүрээнд боловсруулагдаагүй, мөн Жендерийн зорилтот зөрүүтэй байдлын үнэлгээг иш татаагүй байна. Монголын Жендерийн тэгш байдлын үндэсний хорооны гишүүдийг ҮТХН 3.0-ын гамшгийн эрсдэлийн удирдлага, Нийгмийн эрүүл мэнд, амьжиргаа, нийгмийн хамгааллын асуудлаарх дасан зохицлын салбаруудын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд багтаасан боловч харин ҮДЗТ-ний явцад оролцоогүй.</p>
<p>* БОЯБУХ нь уур амьсгалын өөрчлөлт болон биологийн олон янз байдлын доройтлын харилцан уялдааг онцолсон нь илүү нэгдмэл, уялдаа холбоотой хандлагыг бий болгох боломжтой. Гэвч ҮДЗТ болон ҮТХН 3.0 баримт бичигт уур амьсгал, байгаль орчинтой холбоотой нийтлэг өгүүлэмж, мэдэгдлийг оруулаагүй.</p> <p>* Ярилцлагад хамрагдсан оролцогч талуудын дунд Монгол Улсын ҮТХН, ҮДЗТ, БОЯБУХ-ийг үндэсний хөгжлийн төлөвлөгөө, бодлого, стратеги, тэр дундаа Алсын хараа 2050-тай уялдуулах ёстой гэсэн ерөнхий ойлголттой байсан. Эдгээр нь бүгд нийтлэг зорилго, зорилтууд болон үндэсний тэргүүлэх чиглэлүүдэд нэгдсэн байдлаар хувь нэмрээ оруулж байх шаардлагатай. Гэсэн хэдий ч</p>	<p>✗ БОЯБУХ нь уур амьсгалын өөрчлөлт болон биологийн олон янз байдлын доройтлын харилцан уялдааг онцолсон нь илүү нэгдмэл, уялдаа холбоотой хандлагыг бий болгох боломжтой. Гэвч ҮДЗТ болон ҮТХН 3.0 баримт бичигт уур амьсгал, байгаль орчинтой холбоотой нийтлэг өгүүлэмж, мэдэгдлийг оруулаагүй.</p> <p>* Ярилцлагад хамрагдсан оролцогч талуудын дунд Монгол Улсын ҮТХН, ҮДЗТ, БОЯБУХ-ийг үндэсний хөгжлийн төлөвлөгөө, бодлого, стратеги, тэр дундаа Алсын хараа 2050-тай уялдуулах ёстой гэсэн ерөнхий ойлголттой байсан. Эдгээр нь бүгд нийтлэг зорилго, зорилтууд болон үндэсний тэргүүлэх чиглэлүүдэд нэгдсэн байдлаар хувь нэмрээ оруулж байх шаардлагатай. Гэсэн хэдий ч</p>	<p>* БОЯБУХ нь уур амьсгалын өөрчлөлт болон биологийн олон янз байдлын доройтлын харилцан уялдааг онцолсон нь илүү нэгдмэл, уялдаа холбоотой хандлагыг бий болгох боломжтой. Гэвч ҮДЗТ болон ҮТХН 3.0 баримт бичигт уур амьсгал, байгаль орчинтой холбоотой нийтлэг өгүүлэмж, мэдэгдлийг оруулаагүй.</p> <p>* Ярилцлагад хамрагдсан оролцогч талуудын дунд Монгол Улсын ҮТХН, ҮДЗТ, БОЯБУХ-ийг үндэсний хөгжлийн төлөвлөгөө, бодлого, стратеги, тэр дундаа Алсын хараа 2050-тай уялдуулах ёстой гэсэн ерөнхий ойлголттой байсан. Эдгээр нь бүгд нийтлэг зорилго, зорилтууд болон үндэсний тэргүүлэх чиглэлүүдэд нэгдсэн байдлаар хувь нэмрээ оруулж байх шаардлагатай. Гэсэн хэдий ч</p>	

ҮТХН 3.0-ын үйл явц	ҮДЗТ-ний үйл явц	БОЯБҮХ-ийн үйл явц	Хамтын үр нөлөөний үнэлгээ
<p>* ҮТХН 3.0 нь экосистемийг нүүрстөрөгчийн шингээгч чухал бүрэлдэхүүн гэж тодорхойлж, биологийн олон янз байдал, ойн салбарын тодорхой зорилтуудыг тусгасан. Тодорхойлсон зорилтууд нь ҮДЗТ болон БОЯБҮХ-тэй нягт уялдаагүй.</p>	<p>2050"-аас иш татсан бөгөөд тодорхой зорилт, үйл ажиллагаануудыг холбож өгсөн байна.</p> <p>* ҮДЗТ нь экосистем, биологийн олон янз байдал, газрын доройтол, цөлжилтийг дасан зохицох тэргүүлэх чиглэл гэж тодорхойлсон. Холбогдох зорилт нь БОЯБҮХ-ийн зорилттой нягт нийцэж байна. ҮДЗТ болон ҮТХН хоёулаа биологийн олон янз байдал, экосистемийг нэн эмзэг тэргүүлэх салбар гэж тодорхойлсон хэдий ч зорилго, зорилтууд нь хоорондоо төдийлөн сайн уялдаагүй.</p>	<p>холбогдлын талаар иш татсан. БОЯБҮХ-ийн төсөл болон ҮДЗТ-нд тусгагдсан дээд түвшний зорилтуудын хооронд тодорхой хэмжээний давхцал байгаа боловч ҮТХН 3.0-той давхцал бараг байхгүй байна.</p>	<p>агуулгын дүн шинжилгээгээр эдгээр үндэсний стратегиудын ерөнхий зорилтууд нь хоорондоо уялдаа холбоо багатай, холбогдох ишлэл бараг байхгүй байгааг илрүүлсэн.</p> <p>* ҮТХН, ҮДЗТ болон БОЯБҮХ нь экосистем, биологийн олон янз байдлыг нүүрстөрөгчийн шингээлтийн чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд уур амьсгалын өөрчлөлтийн гаралтай болон бусад хүчин зүйлүүдэд өртөмтгий хэмээн тодотгосон байна. Гэсэн хэдий ч холбогдох зорилго, зорилтууд нь харилцан адилгүй байна.</p>

УТХН 3.0-ын үйл явц	ҮДЗТ-ний үйл явц	БОЯБУХ-ийн үйл явц	Хамтын үр нөлөөний үнэлгээ
<p>* УТХН 3.0-т хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, биологийн олон янз байдлыг хамгаалах чиглэлийн мэргэжилтнүүдийг салбарын ажлын хэсгүүдэд оролцуулж, дасан зохицох тэргүүлэх чиглэлүүдийг идэвхтэй уялдуулахыг зорьсон. Уялдаа нийцлийн түвшин нь салбар бүрт харилцан адилгүй байна. УТХН 3.0-т дасан зохицох чиглэлийн нэмэлт үйл ажиллагаануудыг тодорхойлсон. БОЯБУХ-ийн төслийн багийнхан УТХН 3.0-ийн төсөлд</p>	<p>* ҮДЗТ-ний үйл явцад биологийн олон янз байдлын мэргэжилтнүүд оролцсон боловч БОЯБУХ нь үйл явц цаг хугацааны хувьд өөр байсан тул ҮДЗТ тус төсөлтэй уялдаагүй.</p> <p>* ҮДЗТ-г боловсруулахдаа салбар хоорондын бодлогын зөрчил (trade-offs)-ийг үнэлсэн эсэх нь тодорхойгүй байна.</p> <p>✓ "Экосистемд суурилсан дасан зохицох болон байгальд суурилсан шийдлүүдийг дэмжих" нь ҮДЗТ-ний тусгайлан анхаарсан чиглэлүүдийн нэг бөгөөд "Экосистем, биологийн олон янз байдал, газрын доройтол, цөлжилт" нь тэргүүлэх чиглэл юм.</p>	<p>* Төлөвлөлтийн үйл явцад уур амьсгалын өөрчлөлтийн мэргэжилтнүүд оролцсон боловч УТХН 3.0 болон ҮДЗТ-г боловсруулсан мэргэжилтнүүд оролцоогүй.</p> <p>✓ БОЯБУХ-ийн төслийг боловсруулж буй баг ҮДЗТ болон УТХН 3.0-д тусгагдсан арга хэмжээний талаарх олон асуудлыг тодорхойлон БОЯБУХ-ийн хамгаалалтын арга хэмжээнүүдээр дамжуулан эдгээр асуудлыг шийдвэрлэхээр зорьж байна.</p> <p>✓ БОЯБУХ-ийн төсөлд ойн нөхөн сэргээлт, тусгай хамгаалалттай газар нутаг, холбоо хамаарал болон менежментийг сайжруулах, мөн ойн түймрээс урьдчилан сэргийлэх зэрэг экосистемд суурилсан томоохон цар хүрээ бүхий хандлагыг дурдсан байна.</p>	<p>* Төлөвлөлтийн үйл явц бүрд хариуцсан багууд идэвхтэй оролцож, зөвлөлдөх уулзалтуудыг хийж байсан. Гэсэн хэдий ч цаг хугацааны хувьд харилцан адилгүй, удирдлага-зохицуулалтын тодорхой чиглэл, заавар дутмаг байсан, мөн хөгжлийн түншүүд болон зөвлөхүүдэд зориулсан нэгдсэн удирдамжгүй байсан зэрэг нь хамтын хүчин чармайлтыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд бэрхшээл учруулж байсан.</p> <p>* Төлөвлөлтийн явцад арга хэмжээ, үйл ажиллагааны үнэлгээ, түүнтэй холбоотой болзошгүй зөрчил зэрэг нь харилцан адилгүй байдлаар хийгдсэн. Жишээлбэл, УТХН 3.0-ын баг төлөвлөлтийн үе шатандаа бодлогын дүн шинжилгээ хийж, болзошгүй зөрчлийг бууруулах болон хариу арга хэмжээний сөрөг нөлөөллийг бууруулахыг зорьсон. Харин БОЯБУХ-ийн баг болзошгүй зөрчил, сөрөг нөлөөллийг шинжилж, санал болгож буй үйл ажиллагаа нь биологийн төрөл зүйлд хэрхэн нөлөөлөхийг үнэлсэн. Тэд үр дүнгээ УТХН 3.0-ын холбогдох салбарын ажлын хэсгүүдтэй хуваалцаж, БОЯБУХ-т тусгагдсан хамгаалалтын арга хэмжээнүүдээр дамжуулан эдгээр асуудлуудыг шийдвэрлэхээр төлөвлөж байна. Эсрэгээрээ,</p>

ҮТХН 3.0-ын үйл явц	ҮДЗТ-ний үйл явц	БОЯБУХ-ийн үйл явц	Хамтын үр нөлөөний үнэлгээ
<p>саналаа хүргүүлсэн.</p> <p>★ Ерөнхийдөө ҮТХН 3.0 нь болзошгүй зөрчил, сөрөг нөлөөллийг аль болох бууруулахыг зорьсон.</p> <p>✓ ҮТХН 3.0 нь экосистемд суурилсан томоохон цар хүрээ бүхий хандлагыг тодорхойлон, ялангуяа ойн салбарт төвлөрсөн уян хатан, тэсвэртэй экосистемийг бүрдүүлэхийн чухлыг онцолсон.</p>	<p>✓ ҮДЗТ баримт бичигт дасан зохицлын арга хэмжээнүүдийг н зардлыг тусгасан.</p>	<p>✓ Зардлын дүн шинжилгээ хийнэ.</p> <p>✓ Хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргана.</p>	<p>ҮДЗТ-ний баг болзошгүй зөрчил, сөрөг нөлөөллийн үнэлгээ хийсэн тухай тодорхой мэдээлэл байхгүй байна.</p> <p>✓ Үндэсний гурван стратегиуд бүгд экосистемд суурилсан томоохон цар хүрээ бүхий хандлагыг тусгасан байна. Хэдийгээр тодорхой уялдуулж төлөвлөөгүй ч тэдгээрийн давхцаж буй арга хэмжээнүүд нь биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхэд чиглэсэн олон зорилгод хувь нэмэр оруулах болно. Мөн зарим үйл ажиллагаанууд нь давхцаж байгаа ч зорилтот түвшинд авч үзвэл тэдгээрийн тодорхой зорилтууд хоорондоо мэдэгдэхүйц ялгаатай хэвээр байна.</p>
<p>✓ ҮТХН 3.0-ын Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө боловсруулагдаж байна.</p> <p>✓ ҮТХН 3.0-ын зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулагдаж байна.</p>	<p>✓ ҮДЗТ баримт бичигт дасан зохицлын арга хэмжээнүүдийг н зардлыг тусгасан.</p>	<p>✓ Зардлын дүн шинжилгээ хийнэ.</p> <p>✓ Хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргана.</p>	<p>★ ҮТХН 3.0 болон ҮДЗТ-ний үйл явц нь хамтарсан санхүүжилт, хэрэгжилтийг авч үзээгүй. Гэсэн хэдий ч БОЯБУХ-ийг боловсруулах үйл явц нь ҮТХН 3.0 болон ҮДЗТ-нд тусгагдсан биологийн олон янз байдалтай холбоотой арга хэмжээнүүдийг харгалзан үзэж, хамтарсан санхүүжилтийн боломжуудыг эрэлхийлж байна.</p>

УТХН 3.0-ын үйл явц	ҮДЗТ-ний үйл явц	БОЯБУХ-ийн үйл явц	Хамтын үр нөлөөний үнэлгээ
<p>* Монгол Улсын хүлэмжийн хийн үндэсний тооллого одоогоор албан ёсоор бүрдээгүй байгаа тул хамгийн сүүлд гарсан хоёр жил тутмын шинэчилсэн тайланд багтсан тооллогын дүн мэдээг иш татан ашиглаж байна.</p>	<p>✓ ҮДЗТ нь 99 арга хэмжээ, тодорхой шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг багтаасан хяналт, үнэлгээ, сургалтын (MEL) тогтолцоог агуулсан.</p> <p>✗ Дасан зохицох талаарх харилцаа холбооны тухай ойлголт оролцогч талуудын дунд хязгаарлагдмал байна.</p>	<p>✓ Тодорхойлсон үндэсний түвшний бүх арга хэмжээ нь Дэлхийн Куньмин-Монреалын Биологийн олон янз байдлын хүрээ баримт бичгийн зорилтуудтай уялдсан бөгөөд тодорхой шалгуур үзүүлэлтүүдийг агуулсан.</p>	<p>✗ Засгийн газрын оролцогч талууд болон хөгжлийн түншүүдийн олон улсын тайлагналын шаардлагуудын талаарх мэдлэг хязгаарлагдмал байгаа бөгөөд ялангуяа Арабын Нэгдсэн Эмират Улсын Уур амьсгалд тэсвэртэй байдлын тогтолцоо (АНЭУ-ын УАТБТ)-ны хүрээнд тавигдах шаардлагуудын талаар ойлголт бага байна. Тайлагнал нь тогтмол бус, хэсэгчилсэн байдлаар хийгддэг мэт харагдаж байгаа бөгөөд тууштай байдал, стандартчлагдсан журам, төвлөрсөн бүртгэлийн систем дутмаг байна.</p> <p>✗ Парисын хэлэлцээрийн дагуу Дэлхийн нэгдсэн үнэлгээ (Global Stocktake)-ний тайлагнал нь УТХН болон ҮДЗТ-нд ашиглагдаж буй тоон болон чанарын үзүүлэлтүүд бусад бодлогын стратегиудтай хэрхэн нийцэж байгаа нь тодорхойгүй байна. БОЯБУХ-ийн тодорхойлсон зорилтууд болон түүнд холбогдох шалгуур үзүүлэлтүүд нь Куньмин-Монреалын Дэлхийн биологийн олон янз байдлын хүрээ баримт бичгийн зорилтуудтай нийцэж байна. Гурван баримт бичгийн хүрээнд нийтлэг шалгуур үзүүлэлт байхгүй байна.</p>



## 5. Уур амьсгал болон биологийн олон янз байдлын хамтын үр нөлөөний үйл ажиллагааг сайжруулахад тулгарч буй сорилтууд

Ярилцлагын үеэр оролцогч талууд болон шинжээчид Монгол Улсын дотоодын болон улс төрийн нөхцөл байдлын хэд хэдэн сорилтыг онцолж, эдгээр нь уур амьсгалын өөрчлөлт болон биологийн олон янз байдлыг хамгаалах хүчин чармайлт хоорондын уялдаа холбоо, бодлогын нийцлийг бэхжүүлэхэд бэрхшээл учруулж байгааг онцлон тэмдэглэж байв. Үүнд:


- **Монгол Улсын Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам (БОУАӨЯ), Уур амьсгалын үндэсний хороо (УАҮХ) болон Засгийн газрын түвшинд ҮТХН, ҮДЗТ болон БОЯБҮХ зэрэг баримт бичгийг албан ёсоор уялдуулах, харилцан иш татах талаар ямар нэгэн дээд түвшний чиглэл, мандат одоогоор байхгүй байна.** Үүний үр дүнд Монгол Улсын бодлого, төлөвлөлт уялдаа холбоогүй хэвээр байгаа бөгөөд хөгжлийн түншүүд болон бие даасан зөвлөхүүдэд тулгуурласан, төсөл хөтөлбөрүүдэд суурилсан санаачилгуудыг хэрэгжүүлж байна. Энэхүү уялдаа холбоо дутмаг байдал нь үр ашиггүй үйл ажиллагаа, давхардал, боломжит хамтын үр нөлөө алдагдах зэрэг сөрөг үр дагаварт хүргэдэг. Баримт бичгүүдийн хоорондын зөрүү нь уур амьсгал болон биологийн олон янз байдлын чиглэлээрх үйл ажиллагаанууд илүү уялдаа холбоотой, нэгдсэн хандлага баримтлахын ашиг тусыг ойлгох түвшин хангалтгүй байгаатай холбоотой байна.

- **Зохицуулалт хязгаарлагдмал байгаа тул Монгол Улсын уур амьсгал, биологийн олон янз байдлын бодлогын үйл явц тус тусдаа хэрэгжсээр байна.** Жишээлбэл, ҮТХН 3.0-ын дасан зохицлын бүрэлдэхүүн хэсэг нь ҮДЗТ-ний өмнө хийгдсэн дүн шинжилгээнд тулгуурлаагүй байна. Харин уур амьсгалын эмзэг байдал, эрсдлийн үнэлгээг тусад нь хийж, ҮДЗТ-нд хамаарах хэд хэдэн зорилт, арга хэмжээг ҮДЗТ-өөс иш таталгүйгээр өөрөөр тусгасан байна. Үүний адил, боловсруулалтын шатанд байгаа БОЯБҮХ нь экосистем, биологийн олон янз байдал, уур амьсгалын өөрчлөлтийн үзүүлэх нөлөөллийн талаар өөрийн гэсэн тооллого, үнэлгээг хийсэн бөгөөд тус ажлыг ҮДЗТ эсвэл ҮТХН 3.0-ийн багуудтай хамтран гүйцэтгэх боломжтой байсан. Мөн БОЯБҮХ нь ҮТХН 3.0 болон ҮДЗТ-ний хүрээнд биологийн олон янз байдалтай холбоотой хамгаалалтын механизмуудын орхигдол хийдлийг тогтоосон боловч эдгээр орхигдол хийдлийг хамтран шийдвэрлэхийн оронд бие даасан тусгай механизмуудыг хөгжүүлэхээр төлөвлөж байна. Эдгээр давхардлууд нь Монгол Улсын уур амьсгал, биологийн олон янз байдлын төлөвлөлтийн тогтолцоонд илүү хүчтэй уялдаа холбоо, илүү өндөр түвшний нэгдмэл байдал нэн шаардлагатай байгааг харуулж байна.
- **Бодлогын уялдаа холбоо болон хамтын үр нөлөөг хангах асуудлыг хангалттай анхаарч авч үзэхгүй байна.** Оролцогч талууд Монгол Улсын байгаль орчны бодлогын тогтолцооны уялдаа холбоо, хамтын үр нөлөөний талаарх ойлголт хязгаарлагдмал байгааг өмнө онцолсон. Мэдлэг, мэдээллийн түвшин бага, институц хоорондын зохицуулалт сул байгаагаас шалтгаалан хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, биологийн олон янз байдлын бодлогуудыг уялдуулах дээд түвшний чиг үүрэг, мандат одоогоор бүрдээгүй байна.
- **Цаг хугацааны зөрүүтэй байдал.** ҮТХН 3.0, ҮДЗТ болон БОЯБҮХ нь тус тусдаа, өөр өөр цаг хугацааны хуваарьтай бөгөөд хэдийгээр үүнтэй холбоотой олон улсын туршлагаудыг шууд нэвтрүүлэх боломжтой ч Монгол Улсын Засгийн газрын дээд түвшний чиглэл, мандат байхгүй нөхцөлд хоорондын уялдаа холбоог хангахад хүндрэлтэй юм.
- **ҮТХН, ҮДЗТ болон БОЯБҮХ-ийг боловсруулах үйл явцын хүрээнд тулгарч буй томоохон сорилтуудын нэг нь хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, биологийн олон янз байдлыг хамгаалах ахиц дэвшлийг хянах тогтвортой, нэгдсэн хэмжилт, тайлагналт, баталгаажуулалт (MRV) болон хяналт, үнэлгээ, сургалт (MEL)-ын тогтолцоо дутмаг байгаа явдал юм.** Биологийн олон янз байдлын хүрээн дэх зорилт, шалгуур үзүүлэлтүүдийг нийцүүлэх зарим оролдлогууд хийсэн хэдий ч ҮТХН болон ҮДЗТ-д тусгагдсан биологийн олон янз байдлын зорилтууд нь Куньмин-Монреалын Дэлхийн биологийн олон янз байдлын хүрээ баримт бичиг болон шинээр боловсруулагдаж буй БОЯБҮХ-тэй цаг хугацааны хувьд зөрүүтэйгээс шалтгаалан бүрэн уялдаагүй хэвээр байна. Уур амьсгалын бодлого боловсруулагчдын Куньмин-Монреалын Дэлхийн биологийн олон янз байдлын хүрээ баримт бичгийн талаарх мэдлэг хязгаарлагдмал байгаа нь цаашдын уялдаа холбоог хангахад саад учруулж байна. Зорилго, зорилтууд болон шалгуур үзүүлэлтүүдийн уялдаа холбоогүй байдал нь төөрөгдөл, үр ашиггүй байдал, хүчин чармайлтын давхардал, өгөгдлийн менежментийн хүндрэл зэрэг асуудлыг бий болгож байна.


- **Хөгжлийн түншүүдээс хамааралтай байдал.** Олон улсын хөгжлийн түншүүд болон бие даасан зөвлөхүүдэд хэт их түшиглэх нь уур амьсгал болон биологийн олон янз байдлын бодлого, төлөвлөлт, хэрэгжилт нь уялдаа холбоогүй, төсөлд суурилсан хандлага давамгайлахад хүргэдэг бөгөөд энэ нь эцэстээ давхардал, зорилтууд болон арга хэмжээнүүдийн уялдаа холбоогүй байдал, болзошгүй зөрчил (тухайлбал, дасан зохицох үйл ажиллагааны сөрөг хариу урвал)-ийг бий болох нөхцөлийг бүрдүүлнэ.
- **Засгийн газар болон салбарын яамдын техникийн чадавх, мэдлэгийн жигд бус байдал.** Олон талын оролцогчид болон мэргэжилтнүүдийн дурдсанаар төрийн албан хаагчид, ялангуяа салбар яамдын ҮТХН-ийн хэрэгжилт хариуцсан зохицуулагч нарын байнгын халаа сэлгээ, хүний нөөцийн тогтворгүй байдал зэргээс шалтгаалан тэдгээр албан тушаалтнууд нь ҮТХН 3.0-ийг шинэчлэх үйл явц, түүнчлэн БОЯБҮХ болон ҮДЗТ-г боловсруулах ажилд зорилтот чадавхыг бэхжүүлэх сургалт, дэмжлэггүйгээр идэвхтэй оролцох боломжгүй байна. БОУАӨЯ-ны албан хаагчид харьцангуй мэдээлэл сайтай байдаг хэдий ч салбарын яамдын олон албан хаагчид, тэр тусмаа ҮТХН-ийн гол зохицуулагч нар нь ҮТХН-ийн хамрах хүрээ, уур амьсгалын бодлогын талаар ойлголт дутмаг байна. Цаашилбал, УИХ-ын гишүүд болон удирдах түвшний шийдвэр гаргагчдын уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэг мөн л хязгаарлагдмал байгаа нь дээд түвшний манлайлал, дэмжлэг авахад томоохон саад учруулсаар байна.
- **Төрийн албан хаагчдын байнгын халаа, сэлгээ.** Оролцогч талуудын дурдсанаар улс төрийн тогтворгүй байдал, Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний өөрчлөлтөөс шалтгаалан төрийн байгууллагуудын гол албан тушаалтнуудын байнгын өөрчлөлт, халаа сэлгээ нь, урт хугацааны бодлого төлөвлөлт болон институцийн чадавхыг бэхжүүлэх үйл явцад саад учруулсаар байна. ҮТХН 3.0-ийг боловсруулах үеэр зарим гол албан тушаалтнууд солигдсон нь үйл явцыг удаашруулж, бодлогын уялдаа холбоо болон хамтын үр нөлөөг бэхжүүлэх хүчин чармайлтад сөргөөр нөлөөлсөн.

Дараах "Асуудлын мод"-оор тодорхойлсон сорилтууд хэрхэн харилцан уялдаж, нэг нь нөгөөдөө хэрхэн нөлөөлж буйг харуулахыг зорив.

Зураг 1. Асуудлын модны дүн шинжилгээ: Хамтын үр нөлөө



Эх сурвалж: Зохиогчид



## 6. Уур амьсгалын болон биологийн олон янз байдлын хамтын үр нөлөөтэй үйл ажиллагааг бэхжүүлэх боломжууд

Хүснэгт 3-т голлох мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлага, агуулгын дүн шинжилгээ болон тодорхойлсон сорилт, орхигдол хийдлийг үндэслэн гаргасан ерөнхий болон тусгайлсан зөвлөмжүүдийг тоймлон үзүүлэв. Эдгээр зөвлөмж нь үндэсний уур амьсгалын болон биологийн олон янз байдлын бодлогын уялдааг сайжруулж, хамтын үр нөлөөллийг бэхжүүлэхэд чиглэсэн болно.

### Ерөнхий зөвлөмжүүд:

- ✓ БОУАӨЯ-ны институцийн мандат, чадавхыг бэхжүүлж, уур амьсгал болон биологийн олон янз байдлын бодлогын төлөвлөлтийн үйл явцыг үндэсний хэмжээнд нэгдмэл хэлбэрээр удирдан зохицуулах боломжийг нэмэгдүүлэх шаардлагатай. Жишээ нь, зорилтот чадавхыг бэхжүүлэх сургалт, сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх; ҮТХН, ҮДЗТ болон БОЯБҮХ-ийн үйл явцыг уялдуулахад дэмжлэг үзүүлэх; байгууллагын өгөгдөл мэдээллийг хадгалах систем болон мэдлэгийн удирдлагын стратеги эсвэл тогтолцоог хөгжүүлэх; мэдээлэл солилцоог хялбаршуулах хөтөлбөр болон оролцогч талуудын идэвх санаачлагатай байдлыг хангах боломжтой.
- ✓ Нэгдсэн төлөвлөлтийн ач холбогдол болон эдгээр үйл явц хоорондын хамтын үр нөлөөний талаарх ойлголтыг нэмэгдүүлэхийн тулд зорилтот мэдлэгийн түвшинг дээшлүүлэх шаардлагатай бөгөөд энэ нь илүү үр ашигтай, хамтын ажиллагаа

бүхий бодит үр нөлөөтэй хэрэгжилтийг бий болгоно.

- ✓ Хөгжлийн түншүүд нь Монгол улсад уур амьсгалын өөрчлөлт болон биологийн олон янз байдлын талаарх олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх, институцийн чадавхыг бэхжүүлэх санаачилгыг эрчимжүүлэх хэрэгцээ шаардлага байна. Тухайлбал, дээд түвшний шийдвэр гаргагчид болон Улсын Их Хурлын гишүүдэд чиглэсэн хүрээлэн буй орчны доройтол, байгалийн гамшиг, нийгэм-эдийн засгийн хөгжил хоорондын уялдаа холбоог онцолсон боловсрол, сурталчилгааны кампанит ажлыг хэрэгжүүлэх боломжтой юм.
- ✓ Хөгжлийн түншүүд нэн тэргүүнд төрийн албан хаагчид, техникийн мэргэжилтнүүд, ялангуяа салбарын яамдын албан хаагчдын нотолгоонд суурилсан бодлого боловсруулах чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагаанд анхаарал хандуулах шаардлагатай. Хүртээмж, үр ашиг, ач холбогдлыг нэмэгдүүлэхийн тулд олон улсын зөвлөмж, аргачлалыг Монгол хэл рүү орчуулж, нутагшуулах замаар өргөн хэрэглээнд нэвтрүүлж, бодит хэрэгжилтийг сайжруулах хэрэгтэй.
- ✓ 2029-2030 онд боловсруулах 4 дэх удаагийн ҮТХН болон ҮДЗТ, БОЯБҮХ-ийн шинэчлэн боловсруулах үе шатны цаг хугацааны хуваарийг илүү сайн уялдуулах шаардлагатай.

*Хүснэгт 3. Монгол Улсын уур амьсгал болон биологийн олон янз байдалтай холбоотой үндэсний стратеги хоорондын хамтын үр нөлөөг бэхжүүлэх боломжууд*

*Уур амьсгал болон биологийн олон янз байдалд чиглэсэн хамтын үр нөлөөтэй үйл ажиллагааг бэхжүүлэх боломжууд*

*Үнэлгээний элементүүд*

- ✓ **ҮТХН, ҮДЗТ болон БОЯБҮХ-ийн хэрэгжилт хариуцсан холбогдох салбарын яамдын асуудал хариуцсан албан тушаалтнууд болон техникийн мэргэжилтнүүдийн оролцоог тогтмол хангах үүднээс УАҮХ-ны дэргэд техникийн түвшний зохицуулалтын дэд механизмыг байгуулах:** Энэхүү техникийн түвшний механизм нь тууштай яриа хэлцэл, хамтын төлөвлөлт мэдээлэл солилцоог өргөжүүлж дээд түвшний шийдвэр гаргалтыг хялбаршуулах бөгөөд уур амьсгал болон биологийн олон янз байдлын бодлогын хүрээний уялдаа холбоог хангахад чиглэнэ.
- ✓ **Бодлогын уялдаа холбоог бэхжүүлэх:** БОУАӨЯ нь УАҮХ болон Засгийн газар зэрэг дээд түвшний шийдвэр гаргагчидтай хамтран ҮТХН, ҮДЗТ болон БОЯБҮХ гэх мэт уур амьсгал болон биологийн олон янз байдлын хүрээн дэх үндэсний төлөвлөгөөнүүдийг харилцан уялдуулах, жишээлбэл, тус төлөвлөгөөнүүдийн зорилго, зорилтууд болон үйл ажиллагааны чиглэлүүдийг тодорхойлохдоо “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого” зэрэг үндэсний хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг заавал харгалзан үзэж уялдуулах талаар албан ёсны чиглэл өгөх нь зүйтэй. Мөн хөгжлийн түншүүд болон зөвлөхүүд нэгдмэл хүрээнд ажиллах боломжийг олгохын тулд тодорхой зааварчилгаа, зохицуулалтын механизм шаардлагатай.

Дээд түвшний мандат

- ✓ **Боловсруулалтын шатанд буй “Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль”-ийн төслийг Монгол Улсын ҮТХН болон ҮДЗТ хоорондын уялдаа, нэгдмэл байдлыг хуульчлан баталгаажуулах эрх зүйн суурь болгох:** Уг хуулийн төсөлд уур амьсгалын өөрчлөлт болон биологийн олон янз байдлын стратегийн бодлогын баримт бичгүүд хоорондын уялдааг тодорхой хүлээн зөвшөөрч, дэмжсэн заалтуудыг тусгаснаар хамтын төлөвлөлтийг бэхжүүлж, уялдаагүй байдлыг бууруулан, хүрээлэн буй орчны арга хэмжээний үр нөлөөг дээшлүүлэх боломжтой.
- ✓ **Цаашдын бодлого төлөвлөлтөд жендерийн талаарх илүү хүртээмжтэй, олон талт ойлголтыг төлөвшүүлэх зорилгоор зорилтот чадавхыг бэхжүүлэх, мэдлэгийн түвшинг дээшлүүлэх санаачилгуудыг уялдуулан хэрэгжүүлэх:** Үүний хүрээнд жендер, олон нийтийн оролцоо болон нийгмийн хамгааллын тухай ойлголтын ялгааг тодорхой болгож, жендерийн олон талт байдлыг Монгол Улсын уур амьсгал ба биологийн олон янз байдалтай холбоотой бодлого төлөвлөлтийн бүх түвшинд авч үзэж, тусгаж байх шаардлагатай.

- ✓ **Үндэсний стратегиуд хоорондын харилцан уялдааг бэхжүүлэх:** ҮТХН, ҮДЗТ болон БОЯБҮХ зэрэг баримт бичгүүд нь уур амьсгалын эмзэг байдал, хүлэмжийн хийн ялгарал, биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөлөл зэрэг үнэлгээнүүдийг харилцан иш татаж, нийцтэй байдал ба нийтлэг ойлголтыг хангах хэрэгтэй. Энэ нь бодлогын уялдааг сайжруулж, харилцан ойлголцлыг нэмэгдүүлэн, илүү нийцтэй, хамтын үр нөлөө бүхий төлөвлөлтийг дэмжинэ.
- ✓ **Оролцогч талуудын уялдаа холбоо бүхий нэгдсэн оролцоог албан ёсоор баталгаажуулах:** Уур амьсгал болон биологийн олон янз байдалтай холбоотой төлөвлөгөөний бүх үйл явцад оролцогч талууд хоорондын уялдаа холбоог хангах албан ёсны чиглэл гаргах шаардлагатай. Энэ нь хөгжлийн түншүүд болон зөвлөхүүдийн хувьд уян хатан ажлын удирдамжийг багтаах бөгөөд уялдаа холбоогүй, давхардсан үйл явц болон цаг хугацааны зөрүүнөөс үүдэх бодлогын салангид байдлыг бууруулан, үйл явц хоорондын хамтын оролцоог дэмжинэ.
- ✓ **Стратегийн хүрээнд салбарын тэргүүлэх чиглэлүүдийг уялдуулах:** ҮТХН, ҮДЗТ болон БОЯБҮХ-ийн тэргүүлэх салбаруудыг уялдуулахын тулд стратегийн дүн шинжилгээ хийх хэрэгтэй. ҮДЗТ-нд эрчим хүч, зам тээвэр, хог хаягдал зэрэг салбаруудыг нэмэх, БОЯБҮХ-т холбогдох тэргүүлэх салбаруудыг тодорхойлж, салбар

хоорондын төлөвлөлт ба хэрэгжилтийг илүү сайжруулах шаардлагатай.

- ✓ **Стратегийн хүрээнд жендерийн уялдааг стандартчилах:** Жендерийн зорилтот зөрүүний үнэлгээнд тулгуурлан ҮТХН, ҮДЗТ болон БОЯБҮХ-т жендерийн тэгш байдлыг хангах нэгдсэн хандлагыг тусгах шаардлагатай. Хүртээмжтэй, тэгш бодлого бүхий үр дүнд хүрэхийн тулд төлөвлөлтийн бүх шатанд Монгол Улсын жендерийн тэгш байдлын үндэсний хороо зэрэг жендерийн тэгш байдлын чиглэлээрх оролцогч талуудыг тогтмол хамруулах хэрэгтэй.

Үнэлгээ

- ✓ **Үндэсний стратегиудын үзэл санааг нэгтгэх:** Бодлого тодорхойлогчид нь ҮТХН, ҮДЗТ болон БОЯБҮХ-т уур амьсгалын өөрчлөлт болон биологийн олон янз байдлын доройтол хоорондын харилцан хамаарлыг тодорхойлсон нэгдсэн үзэл санааг тусгах шаардлагатай. Энэхүү өргөн хүрээг хамарсан ерөнхий үзэл санаа нь уялдаа холбоо бүхий төлөвлөлтүүдийг бий болгож, дээрх хоёр асуудлыг хамтын үр нөлөөтэй хандлагаар шийдвэрлэх эрмэлзлийг илэрхийлэх болно.
- ✓ **Стратегийн зорилтуудыг үндэсний хөгжлийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулах:** ҮТХН, ҮДЗТ болон БОЯБҮХ-ийг “Алсын хараа-2050” зэрэг Монгол Улсын хөгжлийн илүү өргөн хүрээний баримт бичгүүдтэй тодорхой уялдуулах шаардлагатай. Үүний тулд эдгээр стратегийн бодлогын баримт бичгүүдийн ерөнхий зорилго, зорилтуудыг уялдуулах замаар тэдгээрийн үндэсний тэргүүлэх чиглэлд оруулах хувь нэмрийг бэхжүүлж бодлогын уялдаа холбоог хангах шаардлагатай.
- ✓ **Стратегийн хүрээнд экосистемтэй холбоотой зорилтуудыг уялдуулах:** Экосистем нь нүүрстөрөгч шингээгч бөгөөд эмзэг нөөц тул үүнийг харгалзан үзэж, бодлого боловсруулагчид ҮТХН, ҮДЗТ болон БОЯБҮХ-ийн хүрээнд холбогдох зорилго, зорилт, шалгуур үзүүлэлтүүдийг уялдуулах шаардлагатай. Энэхүү зохицуулалт нь экосистемийн нэгдмэл байдлыг бэхжүүлж, давхардлыг бууруулан, уур амьсгал ба биологийн олон янз байдлын арга хэмжээний үр нөлөөг нэмэгдүүлэх болно.

Дэвшүүлсэн зорилтууд

- ✓ **Төлөвлөлтийн тодорхой чиглэл, уян хатан удирдамж, зааврыг бүрдүүлэх:** Бодлого боловсруулагчид цаг хугацааны хуваарийг уялдуулах, уур амьсгал болон биологийн олон янз байдлын төлөвлөлтийн үйл явцыг зохицуулах албан ёсны чиглэл гаргах шаардлагатай. Үүнийг төлөвлөлтийн мөчлөгийн туршид илүү хамтын, нэгдмэл оролцоог бий болгохын тулд хөгжлийн түншүүд болон зөвлөхүүдийн хувьд авч хэрэгжүүлж болохуйц удирдамж, заавраар хангах хэрэгтэй.

Стратеги, бодлого, арга хэмжээг тодорхойлох

- ✓ **Экосистемд суурилсан хандлагын хүрээнд зорилтуудыг уялдуулах:** Бодлого боловсруулагчид ҮТХН, ҮДЗТ болон БОЯБҮХ-ийн хүрээнд нийтлэг хэрэглэж буй экосистемд суурилсан стратегийн зорилтуудыг уялдуулах, нийцүүлэх дүн шинжилгээг эхлүүлж, хамтарсан хэрэгжилтийн боломжуудыг тодорхойлох дүн шинжилгээг эхлүүлэх нь зүйтэй. Ингэснээр хамтын үр нөлөө нэмэгдэж, давхардал багасаж, уур амьсгал болон биологийн олон янз байдлын үйл ажиллагааны хамтын нөлөөг бэхжүүлэх болно.
- ✓ **Уур амьсгал болон биологийн олон янз байдлын төлөвлөлтийн үйл явц дахь болзошгүй зөрчлийн үнэлгээний аргыг стандартчилах:** Нийцтэй, нотолгоонд суурилсан шийдвэр гаргахын тулд шийдвэр гаргагчид томоохон байгаль орчны төлөвлөгөө (түүний дотор ҮДЗТ)-нүүдийн үйл явцад болзошгүй зөрчлийн үнэлгээг заавал тусгах шаардлагатай тухай чиглэл гаргах хэрэгтэй. Бодлогын нөлөөллийг үнэлэх стандартчилсан тогтолцоог бий болгож төлөвлөлтийн багуудад хуваалцсанаар харилцан суралцаж, биологийн олон янз байдал болон уур амьсгалын зорилтуудыг бэхжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх болно.

- ✓ **Үр ашигтай байдлыг нэмэгдүүлж, давхардлыг бууруулж, уур амьсгал болон биологийн олон янз байдлын арга хэмжээн дэх хамтын үр нөлөөг бэхжүүлэхийн тулд ҮТХН, ҮДЗТ болон БОЯБҮХ-ийн хүрээнд хамтарсан санхүүжилт, уялдаа бүхий хэрэгжилтийг дэмжих:** Шийдвэр гаргагчид БОЯБҮХ-ийн хандлагад тулгуурлан гурван үндсэн баримт бичгийн хүрээнд нэгдсэн төлөвлөлт, нөөцийн зүй зохистой зохицуулалтын тогтолцоог бүрдүүлэх нь зүйтэй.
- ✓ **Бодлогын уялдааг бэхжүүлж, нөхцөлт бус арга хэмжээний санхүүжилтийг баталгаажуулахад чухал ач холбогдолтой тул уур амьсгал болон биологийн олон янз байдлын бодлого боловсруулах үйл явцад Сангийн яамны оролцоог идэвхжүүлэх:** Хүрээлэн буй орчны асуудлын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, салбар дундын нэгдсэн шийдвэр гаргалтыг дэмжихийн тулд нэн тэргүүнд яамны албан тушаалтнууд болон техникийн мэргэжилтнүүдийн зорилтот мэдлэгийг дээшлүүлэх, чадавхыг бэхжүүлэх шаардлагатай.

- ✓ **Олон улсын тайлагналын талаарх мэдлэг, институцийн чадавхыг бэхжүүлэх:** Бодлого тодорхойлогчид нь төрийн байгууллагууд болон хөгжлийн түншүүдийн олон улсын тайлагналтын үүрэг, шаардлагын талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, чадавхыг бэхжүүлэх санаачилгыг нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай. Ялангуяа АНЭУ-ын УАТБТ болон Куньмин-Монреалын Дэлхийн биологийн олон янз байдлын хүрээ баримт бичигт хамаарах үүргийг онцгойлон анхаарах хэрэгтэй. Стандарчлагдсан журам, төвлөрсөн тоо бүртгэлийн системийг бий болгох нь тайлагналтын нийцтэй, уялдаа сайтай, цаг хугацаанд нь хийгдэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- ✓ **Уур амьсгал ба биологийн олон янз байдлын стратегиудын дээд түвшний нийтлэг үзүүлэлтүүдийг уялдуулах буюу тодорхойлох:** Бодлого тодорхойлогчид ҮТХН, ҮДЗТ болон бусад холбогдох баримт бичигт тодорхойлсон чанарын ба тоон үзүүлэлтүүдийг уялдуулах техникийн дүн шинжилгээ хийх ажлыг эхлүүлэх шаардлагатай. Энэ нь Парисын хэлэлцээрийн дагуу Дэлхийн нэгдсэн үнэлгээ (Global Stocktake) болон Куньмин-Монреалын Дэлхийн биологийн олон янз байдлын хүрээ баримт бичгийн Дэлхий нийтийн тойм (Global Review)-д нийцсэн, уялдаа холбоо бүхий тайлагналыг хөнгөвчлөхөөс гадна бодлогын нэгдмэл байдлыг бэхжүүлж, давхардлыг бууруулах болно.
- ✓ **ҮТХН 3.0-ийн хэмжилт, тайлагналт, баталгаажуулалтын (MRV) тогтолцоог хөгжүүлэх** зорилгоор ҮТХН-ийн Түншлэл байгууллагын дэмжлэгтэйгээр хийгдэж буй энэхүү системийг ҮДЗТ-ний хяналт, үнэлгээ, сургалт (MEL)-ын систем, мөн БОЯБҮХ-ийн мониторингийн хүрээтэй уялдуулах стратегийн боломжийг бүрэн ашиглах шаардлагатай. Ийнхүү уялдаа холбоог хангах нь шалгуур үзүүлэлтүүдийг нийцүүлэх, хамтарсан хяналт, тайлагналын үйл явцыг оновчтой болгох, давхардлыг бууруулах ач холбогдолтой. Мөн түүнчлэн, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ) болон НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн Монгол дах суурин төлөөлөгчийн газрууд ҮТХН 3.0, БОЯБҮХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хооронд нь илүү сайн уялдуулж, уур амьсгал болон биологийн олон янз байдлын арга хэмжээн дэх нийцлийг ханган, хэрэгжилтийн үр ашиг, бүтээмжийг сайжруулахын тулд нягт хамтран ажиллах шаардлагатай.

Эх сурвалж: Зохиогчид

## Ашигласан материалууд

- Government of Mongolia. (2020). "Vision-2050" long-term development policy of Mongolia. [https://en.iss.gov.mn/wp-content/uploads/2021/10/2050\\_VISION\\_LONG-TERM-DEVELOPMENT-POLICY.pdf](https://en.iss.gov.mn/wp-content/uploads/2021/10/2050_VISION_LONG-TERM-DEVELOPMENT-POLICY.pdf)
- Government of Mongolia. (2021). New recovery policy. <https://mongoliainc.com/about-mongolia/new-rise-policy/>
- Intergovernmental Panel on Climate Change. (2018). Summary for policymakers. In Global warming of 1.5°C: An IPCC special report on the impacts of global warming of 1.5°C above preindustrial levels and related global greenhouse gas emission pathways, in the context of strengthening the global response to the threat of climate change, sustainable development, and efforts to eradicate poverty [Masson-Delmotte, V., P. Zhai, H.-O. Pörtner, D. Roberts, J. Skea, P.R. Shukla, A. Pirani, W. Moufouma-Okia, C. Péan, R. Pidcock, S. Connors, J.B.R. Matthews, Y. Chen, X. Zhou, M.I. Gomis, E. Lonnoy, T. Maycock, M. Tignor, and T. Waterfield (Eds.)]. <https://www.ipcc.ch/sr15/>
- Ministry of Environment and Climate Change. (2025). National adaptation plan to climate change Mongolia 2024–2030. Government of Mongolia. [https://unfccc.int/sites/default/files/resource/NAP\\_Mongolia\\_2025.pdf](https://unfccc.int/sites/default/files/resource/NAP_Mongolia_2025.pdf)
- Ministry of Environment and Tourism. (2024). Fourth national communication of Mongolia under the United Nations Framework Convention on Climate Change. Government of Mongolia. <https://unfccc.int/sites/default/files/resource/MONGOLIA%20FOURTH%20NC%202024.pdf>
- Qi, J., Terton, A., Khan, M., Matheson, S., & Morales, V. (2024). Effectively Delivering on Climate and Nature: NDCs, NAPs and NBSAPs Synergies (A checklist for national policymakers). Deutsche Gesellschaft für Internationale Zusammenarbeit (GIZ) GmbH. [https://www.adaptationcommunity.net/wp-content/uploads/2025/07/Effectively\\_Delivering\\_Climate\\_Nature\\_Country\\_cases.pdf](https://www.adaptationcommunity.net/wp-content/uploads/2025/07/Effectively_Delivering_Climate_Nature_Country_cases.pdf)
- Security Council Report. (2021). The UN Security Council and climate change (Research report. no. #2). [https://www.securitycouncilreport.org/atf/cf/%7B65BFCF9B-6D27-4E9C-8CD3-CF6E4FF96FF9%7D/climate\\_security\\_2021.pdf](https://www.securitycouncilreport.org/atf/cf/%7B65BFCF9B-6D27-4E9C-8CD3-CF6E4FF96FF9%7D/climate_security_2021.pdf)
- Pörtner, H. O., Scholes, R.J., Agard, J., Archer, E., Arneth, A., Bai, X., Barnes, D., Burrows, M., Chan, L., Cheung, W. L., Diamond, S., Donatti, C., Duarte, C., Eisenhauer, N., Foden, W., Gasalla, M. A., Handa, C., Hickler, T., Hoegh-Guldberg, O. ... & Ngo, H. T. (2021). Scientific outcome of the IPBESIPCC co-sponsored workshop on biodiversity and climate change. IPBES Secretariat. <https://zenodo.org/records/5101125>
- UN Development Programme. (2025). Gender Target Gap Assessment for NDC3.0 and LT-LEDS of Mongolia: identifying gender-specific targets and actions for the nationally determined contribution and long term low emission development strategy. [https://www.undp.org/sites/g/files/zskgke326/files/2025-05/gender\\_target\\_gap\\_assessment\\_for\\_ndc3.0\\_and\\_lt-leds\\_of\\_mongolia.pdf](https://www.undp.org/sites/g/files/zskgke326/files/2025-05/gender_target_gap_assessment_for_ndc3.0_and_lt-leds_of_mongolia.pdf)
- World Bank. (2021). Climate risk country profile: Mongolia. <https://climateknowledgeportal.worldbank.org/sites/default/files/2021-06/15813-Mongolia%20Country%20Profile-WEB.pdf>
- Ойн газар (2026). Ойн сангийн тайлан.

Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ) нь ХБНГУ-ын засгийн газрын тогтвортой хөгжлийн бодлого, зорилтуудыг хэрэгжүүлэхэд нь дэмжин ажилладаг.

Нийтэлсэн: Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ), ХБНГУ-ын Бонн, Эшборн хотуудад оффистой

GIZ Монгол

Найман зовхис барилгын III давхар,  
Сөүлийн гудамж, Сүхбаатар дүүрэг,  
Улаанбаатар 14251, Монгол улс

T: +976 11 312282

E: giz-mongolei@giz.de

I: www.giz.de

Зохиогч:

Анника Тертон, Жеффри Чи, Тогтвортой  
Хөгжлийн Олон Улсын Хүрээлэн (IISD)

Хариуцсан:

Анна Шройөгг, Олон улсын Уур Амьсгалын  
Санаачилга (IKI)-ийн “Парисын  
хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг  
үзүүлэх нь” (SPA) төслийн удирдагч

Бастиан Флүри, GIZ Монгол, Байгаль орчны  
төслийн удирдагч

Энэхүү бүтээлийг ХБНГУ-ын Бундестагийн шийдвэрийн дагуу дагуу Германы Байгаль орчин, Уур амьсгалын үйл ажиллагаа, Байгалийн хамгаалал, Цөмийн аюулгүй байдлын яам (BMUKN)-ны Олон улсын Уур Амьсгалын Санаачилга (IKI)-ын санхүүжилтээр Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ) хэрэгжүүлж буй “Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх нь” төслийн хүрээнд хүрээнд бүтээв.

Үүнд тусгагдсан агуулга нь Тогтвортой Хөгжлийн Олон Улсын Хүрээлэн (IISD) болон GIZ-ийн албан ёсны байр суурийг илэрхийлээгүй болно.

Дизайн: GIZ Монгол

Зураг: GIZ Монгол

Талархал:

Тус судалгаа, шинжилгээний ажлыг гүйцэтгэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан оролцогч талууд болох Монгол Улсын Засгийн газар, холбогдох яамд, агентлагууд, олон улсын болон иргэний нийгмийн байгууллагуудад гүнээ талархал илэрхийлье.

Вэб холбоосууд:

Энэхүү хэвлэлд гадаад вэбсайтууд руу чиглэсэн холбоосууд багтсан болно. Эдгээр гадаад сайтуудын агуулгын хариуцлага нь тухайн сайтуудын эзэмшигч, нийтлэгчдэд бүрэн хамаарна. Холбоосуудыг анх нийтлэх үед GIZ нь гуравдагч этгээдийн агуулгыг шалгаж, иргэний болон эрүүгийн хариуцлага үүсгэх эсэхийг үнэлсэн. Гэвч тодорхой зөрчлийн шинж тэмдэг илрээгүй тохиолдолд гадаад сайтуудын холбоосыг байнга хянахыг шаардах нь бодитой бус юм. Хэрэв GIZ нь өөрөө мэдэх буюу гуравдагч этгээдээс мэдээлэл авч, өөрийн холбоос байршуулсан гадаад сайт нь иргэний болон эрүүгийн хариуцлага үүсгэх нөхцөл бүрдүүлж байгааг тогтоовол, тухайн сайтад чиглэсэн холбоосыг нэн даруй устгана. GIZ нь ийм агуулгаас ил тод татгалзаж байгаагаа мэдэгдэж байна.

Улаанбаатар, 2026 оны 04-р сар